



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-49

1. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг	7-37
---	-------------

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	37-49
--	--------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Б.Бейсен, П.Ганзориг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, О.Саранчулуун, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Б.Жавхлан;

Тасалсан: Х.Тэмүүжин;

Хоцорсон: Н.Алтанхуяг-02 минут, С.Амарсайхан-2 цаг 05 минут, Т.Аубакир-01 минут, М.Бадамсүрэн-59 минут, Д.Батбаяр-08 минут, Х.Баттулга-04 минут, П.Батчимэг-01 минут, Э.Батшугар-56 минут, С.Ганбаатар-30 минут, Д.Ганбат-02 минут, Ц.Даваасүрэн-48 минут, Т.Доржханд-47 минут, Б.Дэлгэрсайхан- 1 цаг 08 минут, Б.Жаргалан-1 цаг 11 минут, Ч.Лодойсамбуу-01 минут, Э.Одбаяр-1 цаг 51 минут, Б.Пунсалмаа- 15 минут, Б.Пүрэвдорж-01 минут, Б.Түвшин-11 минут, Г.Тэмүүлэн-18 минут, А.Ундраа-07 минут, Г.Хосбаяр-12 минут, Да.Цогтбаатар-12 минут, Д.Цогтбаатар-1 цаг 02 минут, Б.Чойжилсүрэн-11 минут, Ө.Шижир-01 минут, Д.Энхтуяа-29 минут, Р.Эрдэнэбүрэн-17 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 76 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсныг танилцуулав. /14:05/

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийн үеэр Улсын Их

Хурал дахь Ардчилсан намын бүлэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу завсарлага авсан талаар тайлбар хийв.

Нэг.“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Хүний эрхийн дэд хороо хариуцсан референт Л.Хурцбилэг нар байлцав.

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нар тус тус танилцуулав.

Танилцуулга болон санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Энхбаяр, Л.Мөнхбаясгалан, Н.Алтаншагай, Д.Энхтүвшин, Л.Энхнасан, М.Ганхүлэг, Б.Уянга нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Сайнзориг, Ц.Идэрбат, А.Ариунзаяа, Н.Наранбаатар, Ж.Батсуурь, Б.Батбаатар, Ч.Лодойсамбуу, Ө.Шижир, Д.Ганбат, Д.Батбаяр нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:49/

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны зөвлөх Д.Нямбаяр, Хүний эрхийн дэд хороо хариуцсан референт Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Цэцийн дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар тус тус танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Д.Энхтүвшин нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:28/

Уг асуудлыг 16 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 02 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Ирц 56.3 хувьтайгаар өнөөдрийн чуулган 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулган эхлэхэд бэлэн болсон байна. Хуралдааныг 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 2 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээрт, “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Хоёрт нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцэхээр байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчдаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гээд заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг зэрэг нарын 76 гишүүн 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгэм бодлогын байнгын хороонд хуваарилсан.

Улсын Их Хурлын гишүүд өнгөрсөн 5 дахь өдөр буюу 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр болсон нэгдсэн чуулганы үеэр Ардчилсан намын зүгээс Төсвийн хэлэлцүүлгийн үеэр завсарлага авсан тухай олон нийтэд Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай, чуулганы хуралдааны дэгийн тухай хууль зөрчсөн эсэх талаар бас зөв, буруу ойлголтууд нэлээдгүй явж байх шиг байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга үүн дээр тайлбар өгч, мэдээлэл хийнэ үү гэж хүсэж байна. 1 номерын микрофоныг өгье.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дэд дарга болон Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2025 оны 9 сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан буюу Төсвийн хуулийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж байх үед Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд даргаас завсарлага авсан. Тэгээд энэ асуудлаар цахим, хэвлэл мэдээллийн хэрэгслээр Дэгийн хуулийг зөрчсөн, холбогдох Их Хурлын тухай хуулийг зөрчсөнтэй холбоотой асуудал яригдсан. Үүнтэй холбоотойгоор би гишүүддээ хэлэхэд яг тухайн өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан Төсвийн тухай хуулийн нэг дэх хэлэлцүүлэг бол яг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмынхаа дагуу явсан.

Ардчилсан намын бүлгийн дэд дарга Жаргалан дарга бол Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу тухайн асуудлаар завсарлагыг үргэлжлүүлэн авах ийм эрх нь байдаг. Тухайн хуралдаан даргалагч бүлгийн эрх, үүрэг буюу бүлэг завсарлага авах юм уу, эс үгүй бол үргэлжлүүлж авах нөхцөлд тухайн завсарлагын хугацааг өгөх буюу эс үгүй бол үргэлжлүүлж өгөх тийм үүрэг нь Дэгийн тухай хуулиараа хуульчлагдсан байдаг.

Тэгэхээр Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд хэлэхэд тухайн өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан аль ямар нэгэн Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөрчөөгүй болно гэдэг зүйлийг хэлье.

Х.Булгантуяа: Хэлэлцэх асуудалдаа оръё.

““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөр дарга танилцуулна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөрийг индэрт урьж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

А.Үйлстөгөлдөр: Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд дараах үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчилсэн хориг тавьж байна.

1.Монгол Улс тусгай хамгаалалтад авсан газар нутгийг нэмэгдүүлж, байгаль орчноо хамгаалах бодлого баримтлах ёстой. Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолын 5 дугаар заалтад алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Улсын Их Хурлын 20 оны 46, 47 дугаар тогтоолуудад өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Энэхүү яаралтай өргөн мэдүүлж өөрчлөлт оруулахаар дурдсан Их Хурлын 20 оны 46, 47 дугаар тогтоолууд нь зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн байдаг.

Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх бодлого тууштай хэрэгжих нь зүйтэй боловч энэ хүрээнд алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, түүний хилийн заагийг өөрчилж тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг багасгах хууль зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу экологийн аюулгүй байдлыг хангах, түүний тэнцвэрийг хадгалах, байгаль орчин, ой, усны сан бүхий газрыг хамгаалах, цөлжилттэй тэмцэх нь үндэсний аюулгүй байдлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэн ховор, ховор болон эко системд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэхээр тусгасан байдаг.

Иймд байгаль орчны талаарх төрийн бодлого цаашид өнөөгийн улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тогтоол нийцүүлэх нь зүйтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина хэмээн тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт энэ хуулийн 46.4-д заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд энэ тогтоолыг Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсэгт заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг зөрчих шинжийг агуулсан байна.

Иймд дээр дурдсан үндэслэлээр ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна. Батжаргал гишүүнийг индэрт урья.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан хоригийг Төсвийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутагт байгаа алтны үндсэн ордуудтай холбогдох эдийн засгийн тооцоолол болон байгаль орчинд учруулах хор хохирол, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн эсэх, мөн алтны ордуудын нөөцийг нэмэгдүүлэх эрх зүйн орчны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан тусгай хамгаалалттай газар нутагт алт олборлох, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо судалгаа хийгдсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, нэмэгдүүлэх бодлогыг баримтлах нь зүйтэй талаар үг хэлж, тухайн бүс нутгийн улсын тусгай хамгаалалтад тухайн тусгай хамгаалалтай газар нутгийг тусгай хамгаалалтад авсны үнэ цэн, ач холбогдол, экологийн тэнцвэр алдагдах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг сэргийлэх зэрэг олон нөхцөл байдлын үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэсэгчлэн тавьсан хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар хориг тавьсан тухайн зүйл, хэсэг, заалт нэг бүрээр санал хураалт явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын нэг дэх заалтын 5 дахь дэд заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 85 хувь буюу 17 нь хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн.

Харин Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 95 хувь буюу 19 нь хүлээн авах боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн

байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Эрдэнэболд гишүүнийг индэрт урьж байна.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 88 дугаар тогтоолд хэсэгчлэн хориг тавьж, Монгол Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Үйлстөгөлдөр танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрх, тогтоолын 5 дахь дэд заалтад тавьсан хоригийн хууль зүйн үндэслэл, эдийн засгийн тооцоо судалгаа, тогтоолын дагаж мөрдөх хугацаа, тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн зааг, Ерөнхийлөгчийн хориг тавих үндэслэл зэрэг асуудлуудын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир нар асуулт асууж, хариулт авч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар хориг тавьсан тухайн зүйл, хэсэг, заалт нэг бүрээр санал хураалт явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын нэг дэх хэсэгт заасан нэг дэх заалтын 5 дахь дэд заалтад болон энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн 3 дахь заалтад тус тус тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 76.5 хувь буюу 13 гишүүн хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын нэг дэх заалтын 5 дахь дэд заалт болон 3 дахь заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Алтанхуягийн Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гочоогийн Ганболд Ерөнхийлөгчийн зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Асуулт, үг хамтдаа. Нийтдээ 19 гишүүд нэрээ өгсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Ажлын хэсгээс асуулт тодруулах зүйл байгаа юм. Энэ үндэслэл дээр энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 6 бүлгийн 1-ийг эш татсан байгаа. Тэгэхээр ер нь ингээд өмнө нь бас бид нар хэлээд байгаа энэ аудитаас, Улсын аудитын газраас Монгол Улсын төсвийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх тал дээр дүгнэлт гаргах ийм хууль, эрх зүйн зохицуулалт байгаад байгаа юм. Гэхдээ бодит байдал дээр аудит энийгээ хийж чадахгүй байгаад байгаа юм.

Яагаад гэхлээр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа төсөв нийцэж байгаа эсэх асуудлаар шалгуур үзүүлэлт тодорхойгүй гэж үзэж байгаа. Сая 5 сард Аудитын газрын даргаар Магнайсүрэн даргыг томилогдоход бас энийг ингээд хөөцөлдөөч ээ гэсэн. Эрх зүйн зохицуулалт нь болохлоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр энэ шалгуур үзүүлэлт нь гарах юм байна лээ.

Тэгээд яагаад энийг хэлж байгаа вэ гэхлээр ер нь цаашдаа энэ төсөвтэй холбоотой, мөн төсвийг бүрдүүлэх эх сурвалжтай холбоотой эдгээр асуудал дээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдгээр асуудал нийцэж байгаа эсэх талаар хяналт хийхийн тулд энэ дээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэ Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар орж байгаа. Энэ Бямбажаргал дарга Аюулгүй байдлын зөвлөл дээр энэ асуудлыг нэг тийш нь болгомоор байна. Энэ дээр бас Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын хувьд Үйлстөгөлдөр дарга бас анхаарал хандуулж ажилламаар байгаад байгаа юм. Тэгэхгүй болохоор ер нь нийтлэгээрээ бид нар энэ асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай.

2.Энэ ер нь төр энэ бодлогоор ингээд нэгдсэн энэ зохицуулалт хийхгүй бол маш хүнд байдалтай байна. Одоо Сэлэнгэ аймгаас иргэдээс ирсэн гомдлыг би та бүхэнд бас заавал танилцуулах ёстой байна. Энэ Алт-3 хөтөлбөрийн сургаар юу болж байна вэ гэхлээрээ байгалийн онгон дагшин байдлыг алдагдуулж, их хэмжээний асуудал гарсан. Сэлэнгэ аймгийн жишээлбэл Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгонд гэхэд гадаад улсын 232 иргэн ажиллаж байгаа. Би тэгээд мэдээсэй гэж бодоод тэнд байгаа компаниудын үйл ажиллагаануудын талаар нэг товчхон мэдээлэл өгөхөд 8 компани дээр очоод манай Засгийн газрын салбар яам нь очоод лацдаад ломбодохлоор 7 компани буцаагаад маргааш нь лацаа аваад үйл ажиллагаагаа явуулчхаж байгаа юм. Маш их хэмжээний хүнд машин механизм, тоног төхөөрөмжүүдийг ойд аваачиж нуугаад хулгайгаар энэ ажил явж байгаа. 1

Монгол компани бол лацаа авахгүй, 7-н Хятад компани лацаа авч байгаа. “Түм их эрэлд” 48 гадаад хүн ажиллаж байгаа ийм компани. Чинхай, Лян Хай инженеринг 43, Зон Мин Шин Мэй гэдэг 13, “Чамин алт” 31, Жин Минг Да гэдэг газар 35 гадаад хүн, Лон Фү Жи Фан гэдэг газар 48 гадаад хүн, Эрхэс-Оюун-Ундраа 13 гадаад хүн, Хан Жоу, Хэн Чин, Хан Жин гэдэг газар 1, Хүчийн бүрэн 2, “Эрдэс Холдинг” гэхэд дан Монголчууд, Баянцагаан констракшн 1 гээд нийтдээ 230-аад хүмүүс ажиллаж байгаа. Энэ Монгол Улсын хууль үйлчлэхгүй, иргэд нь энэ дээр маш их эргэлзэж байна. Тэгээд төр улс байж байж энэ дээр асуудал тавимаар байгаа юм. Энэ талаар бас тодруулга авмаар байна. Хаана алдаа гараад байгаа юм бэ?

Х.Булгантуяа: Нэмээд тодруулчихъя тэгэх үү Эрдэнэболд гишүүн. Ажлын хэсгээс хариулах уу, эс үгүй бол холбогдох Засгийн газрын сайд байхгүй байна. Тэгэхээр ажлын хэсгээс л хариулж таарах гээд байна даа. 4 номерын микрофон.

А.Үйлстөгөлдөр: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Энэ асуудлыг бид нар бас анхаарч авч үзье гэж хариулмаар байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай асуулт асуусан энэ тухай бол бид нар дараагийн асуудлаар бас авч үзье ээ гэж бодож байна.

Х.Булгантуяа: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Ерөнхийдөө ингээд байгаа юм. Одоо яг Өлзийтөгөлдөр дарга аа одоо ингээд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх тал дээр шалгуур үзүүлэлт тогтоох асуудал нь болохлоороо Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд шалгуур үзүүлэлтээ тогтоохгүй байгаад байгаа. Тэгвэл бид нар одоо яаж байна гэхлээрээ жилийн жилд төсөв хэлэлцээд явахлаар, ер нь төсөвтэй холбоотой асуудал ярихаар аль газрын атаман хүчтэй байна. Тэр өөрсдөө төсөв татах гээд үзээд байгаа байхгүй юу. 5 тэрбум гэнэ үү, 10 тэрбум гэнэ үү гишүүний мөнгө гэнэ үү ингээд л тойрог тойрог руугаа бягдаж татах гээд байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт засаг яаж байна гэхлээрээ тэрнийх нь нөгөө тогтвортой оршихын тулд тэрнийх нь барьцаанд орчих гээд тийм зовлонтой болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд сүүлдээ яаж байна гэхлээрээ тойргийн гишүүд, жагсаалтын гишүүд гэдэг хуваагдал үүсдэг ч гэдэг юм уу, зарим нь ард түмнийхээ төлөө, зарим нь болохоор ард түмнийхээ төлөө биш гэсэн ийм хийсвэр гажуудал үүсчих гээд байгаа байхгүй юу. Гэтэл энэ төсөв чинь өөрөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд энэ төсвийн бүрдүүлбэр нийцэж байгаа эсэх тал дээр тэр хяналт тавих шалгуур үзүүлэлт нь өөр.../минут дуусав./

Х.Булгантуяа: Эрдэнэболд гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Б.Энхбаяр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг бид хэлэлцэж байгаа 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан тогтоолд 2 үндэслэлээр хориг тавьсан. Энэний 2 дахь үндэслэл нь 2025 оны 7 сарын 9-ний өдөр баталсан энэ тогтоолыг баталсан өдрөөсөө буюу 25 оны 7 сарын өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан хориг тавих үндсэн бүрэн эрхэд халдаж шууд үйлчлүүлсэн байна гэдэг

үндэслэлээр хориг тавьсан. Тийм учраас би энэ хоригийг хүлээж авах хууль зүйн үндэслэлтэй хүлээж авна гэсэн ийм байр суурьтай байна.

Учир нь энэ асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор урьд нь мөн шийдвэр гарч байсан. Тухайн үед баталсан. Баталсан өдрөөс нь хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй гэсэн энэ заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхэд халдсан байна. Мөн Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй гэдэг Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна гэдэг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарч байсан.

Тийм учраас бид энэ хоригийг хүлээж авч залруулах ёстой. Энэтэй холбоотой Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр ганцхан энэ тогтоолыг дагаж тэр өдрөөс нь дагаж мөрдүүлчихсэн юм биш биз дээ? Өөр ийм баталсан өдрөөс нь дагаж мөрдөнө гэж хуулиуд баталсан уу гэдгийг би асуусан. Чуулган дээр надад урьдчилаад ирүүлээрэй гэсэн ирүүлээгүй байгаа. Би тэгээд үзсэн чинь 2025 оны 7 сарын 9-ний өдөр 40, 50 хууль Улсын Их Хурал нэг амьсгаагаар 32 цагаан лонх тоолж баталсан байна. Энэ баталсан бүх хуулиуд тухайн өдрөөсөө хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй гэсэн заалттайгаар баталсан байна буюу саяын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсанчлан Үндсэн хуулийг зөрчсөн эрх зүйн үр дагаврыг бий болгосон байна.

Тухайлбал, одоо бид төсвийг хэлэлцэж байгаа. Төсвийн хэлэлцэх дэгт оруулсан өөрчлөлтийг 25 оны 7 сарын 9-ний өдрөөс буюу мөн өдрөөс нь хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй гэж хууль баталсан байна. Өөрөөр хэлбэл бид Үндсэн хуулийн зөрчилтэй эрх зүйн нөхцөл байдалд 2026 оны төсвийг хэлэлцэж байна. Сайшаалтай нь Монгол Улсын Ерөнхийлөгч бас тэр хуульд бол хориг тавиагүй юм байна энэ үндэслэлээр. Улсын төсөв нь баларчихвал улс нь баларчихна гэж бодсон байх. Дагасан тогтоол дээр л сая хэлсэн үндэслэлээр баталсан байна. Тэгээд энэ асуудлаар би Улсын Их Хурлын удирдлага Тамгын газрыг тайлбар хийлгэж хүсэх гэж байна.

Х.Булгантуяа: Энхбаяр гишүүний асуулттай холбоотой 1 номерын микрофон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга.

Б.Баасандорж: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Сая Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга танилцуулсан. Яг тэр танилцуулгад яг саяын Энхбаяр гишүүний хөндсөн 2 дахь хоригтой холбоотой асуудал яг өгүүлбэрийнхээ төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг зөрчих шинжийг агуулсан байна л гэсэн байгаа. Яг хориг дээр зөрчих шинжийг. Тэгэхээр би энэ дээр гишүүддээ хэлэхэд яг энэ Ерөнхийлөгчийн яг энэ зөрчих шинжийг агуулсан байна гэж хэлсэн. Их Хурлаас батлагдаж байгаа тэр дундаа батлагдсан өдрөөсөө дагаж мөрдөж байгаа хуульд ямар нэгэн хууль тогтоомжийн зөрчил байхгүй ээ гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Хуульд өөрөөр заагаагүй бол. Тэгэхээр Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхүүдийн хамгийн чухал нэг эрх нь бол хууль тогтоох бүрэн эрх байдаг. Ерөнхийлөгчийн онцгой нэг бүрэн эрх нь бол Их Хурлын баталсан шийдвэрт хориг тавих онцгой бүрэн эрх байдаг.

Тэгэхээр энэ манай Улсын Их Хурлаас баталсан өдрөөсөө хуулийг дагаж мөрдөж байгаа нь бол Ерөнхийлөгчийн маань бол энэ онцгой бүрэн эрхийг хөндөөгүй гэж үзэж байгаа. Яагаад хөндөөгүй гэж үзэж байна гэхээр Ерөнхийлөгчийн хориг тавих 5 хоногийн хугацаанд тухайн тавьсан зүйл, заалт үйлчлэл нь түр зогсдог.

Жишээ нь яг энэ хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын тогтоолыг тухайн үед баталчхаад яг энэ Ерөнхийлөгч 7 сарын 21-ний өдөр хориг тавьсан гээд тайлбартайгаар Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэн. Үйлчлэл нь түр зогсчихсон байгаа. Манай Их Хурал үйлчлээд шийдвэрлэсний дараа энэ үйлчлэл сэргэнэ. Шийдэгдсэний дараа. Сая мөн Энхбаяр гишүүн 2025 оны 7 сарын 9-ний өдөр 40, 50-н хууль баталсан гэж байна. 40, 50-н хууль Энхбаяр гишүүн ээ батлаагүй ээ. 7 сарын 9-ний өдөр 33 хууль, 11 тогтоол хэлэлцэж баталсан.

Үүнээс 7 сарын 9-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан 18 хууль л байгаа. Ер нь тэр Цэцийн 03, 04 дүгээр дүгнэлт, 16 оны 03 дугаар дүгнэлт бол тухайн маргааныг хэлэлцсэнтэй холбоотой л 04 дүгээр дүгнэлт. Өөрөөр хэлбэл, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуультай холбоотойгоор Цэцийн шийдвэр гарсан. 16 оноос хойш батлагдсан өдрөөс нь дагаж мөрдөж байгаа маш олон хууль, тогтоолууд байгаа.

Жишээ нь, 20 оны Их Хурлын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай, 21 оны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай, таны ахалж байсан Хянан шалгах түр хороо, Хөгжлийн банкны хянан шалгах түр хороо яг баталсан өдрөөс нь дагаж мөрдөж байсан. Энэ асуудлаар Цэц өөрийн санаачилгаар ямар нэгэн дүгнэлт, шийдвэр бол гаргаагүй. Тэгэхээр энэ дээр бол Үндсэн хууль болон Дэгийн тухай хуулийн ямар нэгэн зөрчилтэй зүйл байхгүй. Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг бол зөрчих шинжийг агуулаагүй ээ гэж үзэж байна.

Х.Булгантуяа: Энхбаяр гишүүн нэмж тодруулна.

Б.Энхбаяр: Энэ асуудлаар Үндсэн хуулийн цэц хэрвээ шийдвэр гаргавал Баасандорж дарга та улс төрийн хариуцлага хүлээхэд бэлэн байна уу гэдгийг би одоо протоколд үлдээмээр байна. Дандаа ийм улс төрийн асуудлаар орж ирж худлаа тайлбар хийдгээ боль. Энэ Булгантуяа дарга санаатай дэг зөрчөөгүй, сая дэг зөрчөөгүй гээд л түнтгэнээд л байна. Дэг зөрчсөн шүү дээ. Хэлэлцэж байгаа асуудлаар завсарлага авна гэж байгаа болохоос биш, хэлэлцээгүй өөр асуудлаар завсарлага өгнө гэсэн хууль байхгүй шүү дээ. Завсарлаад дуусчихсан, завсарлага нь дуусчихсан асуудлыг 3 сарын дараа гэнэт ухаан орсон юм шиг үргэлжлүүлье гэдэг дэг байхгүй. Юугаа худлаа хууль тайлбарлаад байгаа юм. Битгий энэ Улсын Их Хурлын удирдлагуудыг Үндсэн хууль зөрчих, улс төрийн хариуцлага үүрэх ийм нөхцөл байдалд оруулаад бай л даа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчлэн хориг тавьсан. Гэхдээ энэ 85 дугаар тогтоолд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн баригдаж орж ирэхдээ тэр 1.5 дахь заалт томъёологдож орж ирээгүй юм. Энэ Их Хурлын ажлын хэсгийн түвшинд томъёологдоод орчихсон. Монгол Улс энэ уур амьсгалын өөрчлөлт хүчтэй явагдаж байна, байгаль орчны хамгаалал, эко системийн тэнцвэртэй байдлыг хангая иймийн учир тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэе гэсэн бодлого, чиглэлийг урт болоод, дунд хугацааныхаа бодлогын баримт бичгүүдэд тусгаад оруулчихсан юм.

Гэтэл Их Хурлын тэр 46, 47 дугаар тогтоол бол тодорхой газар нутгуудыг улсын тусгай хамгаалалтад авах шийдвэр байсан. Үүнийг судалж тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлыг бууруулах ийм хэмжээний асуудал хөндсөн нь энэ Монгол Улсын баримталж байгаа бодлого, чиглэлтэй зөрчилдөж байна гэж үзсэн юм байна гэж би бол ингэж үзэж байгаа. Тийм учраас энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг бид хүлээж авах ёстой.

Цаашид ер нь Улсын Их Хурал бас энэ улс орныхоо хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг нэгэнтээ баталж байгаа бол түүний хэрэгжилтийг тогтвортой хангах бодлогын дэмжлэгээ үзүүлж явах ёстой. Үүн дээр бид нэлээн анхаарал хандуулах ёстой юм. Тийм учраас Улсын тусгай хамгаалалтад авах газрын нэгж талбарын судалгаанууд, талбайн хэмжээнүүд судлагдаад бэлэн болчихсон газрууд нэлээдгүй байгаа.

Тийм учраас би Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдыг бол тэр бэлэн болсон асуудлуудыг оруулж ирж энэ тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээнүүдийг цаашид нэмэгдүүлэх талын асуудлыг аваач ээ гэдэг нэг ийм.

Хоёрдугаарт, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах, менежментийг сайжруулах, хамгаалалтын тэр горимуудыг нь хязгаарлалтын бүсүүдийг нь зөв тогтоох энэ асуудал руу бид анхаарахгүй бол болохгүй байгаа юм. Дэлхийн анхны дархан цаазат газар болсон энэ Богд уулын асуудал, Горхи-Тэрэлжийн асуудлууд, цаашид энэ тусгай хамгаалалттай газар нутгууд дээгүүр давтагдахгүй гэх юм тийм баталгаа байхгүй. Тэгэхээр үүнийг бид энэ бэлээнхээ сургамж дээрээ тулгуурлаж цаашид сайжруулах арга хэмжээг авах ёстой шүү гэдгийг би зориуд хэлмээр байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Гишүүддээ бас өдрийн мэнд хүргэе. Би Ерөнхийлөгчийн энэ хоригтой холбоотойгоор Төсвийн байнгын хорооноос оруулж ирж байгаа энэ санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж байна. Ерөнхийдөө тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалт дээр тавьсан асуудлыг бид хүлээн авах, 3 дээр 3 дахь заалт буюу хүчин төгөлдөр болохтой холбоотой тэр аваагүй энэ асуудал агуулгаараа зөв логикийн хувьд зөв байгаад байна. Яг өнөөдрийн нөхцөлд логик нь зөв байгаад байна.

Тэгэхдээ энэ дээр нэг зүйлийг бас анхаараач ээ гэж би хүсэж байгаа юм. Өнөөдөр яах вэ энэ Улсын Их Хурлын тогтоол Алт хөтөлбөр гэдэг юм уу, энийгээ бас зүгээр анзаарахгүйгээр энд тодотгохгүйгээр харах юм бол хууль санаачилж болохгүй ээ гэдэг дээр хориг тавьчихаж байгаа юм.

Тэгэхээр уг нь энэ нэг дэх заалтын 5 дахь заалт маань ер нь зүгээр ийм чиглэл болгосон буюу тодорхой тогтоолын төслийг оруулж ирээч ээ гэдэг чиглэл байхгүй юу. Уг нь бодлого нь гараад тэр бодлого эсвэл буруу батлагдсан тохиолдолд тавьсан бол цааш цаашдаа их зөв логик байсан юм болов уу гэж зүгээр би хувьдаа бодож байгаа юм. Яг энэ дээр тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах асуудлыг ингээд тэр чигтээ хаагаад тавьчихаж байгаа юм биш биз дээ? Магадгүй өөрчлөлтүүд өөр агуулгаар ч байж болно. Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх байдаг юм уу? Тэгэхээр энэ агуулга маань өөрөө эргээд яг бүрэн протоколтойгоо л уншигдахгүй бол ер нь их тийм сонин логик үүсээд үлдэж байна. Тэгэхээр энийг би зориуд тавьж байна ер нь зүгээр цаашдаа тусгай хамгаалалттай газар нутгийг хэмжээг багасгаж болохгүй ээ гэдэг логигоор тавьсан юм байна гэж Ерөнхийлөгчийн хоригийг бид ойлгоод байгаа явах юм болов уу гэсэн ийм зүйл байна.

3 дахь заалт байна. 3 дахь заалтыг бид нар хүлээж авна. Энийг бол хүлээж авах ёсгүй. Хэрэвзээ хүлээгээд авах юм бол энэ зүгээр ердийн журмаараа буюу хэвлэгдсэнээрээ л хүчин төгөлдөр болж байгаа юм. Яг тэр төсвийн хууль хүчин төгөлдөр болох тэр заалттай холбож өнөөдрийн байдлаар тайлбарлах ямар ч боломжгүй. Тэр хууль дээр тавиагүй байхгүй юу. Тэгэхээр бид хэд цаашдаа энэ тавьсан тогтоолынхоо хүрээ хязгаартаа тавихгүй бол яг одоо хууль зүйн техникийн хувьд шууд тэд нартаа ургуулан одоо авч үзэх нь бас буруу байгаа юм.

Тийм учраас энэ тогтоолыг хэрэвзээ хүлээж авахгүй байх юм бол үүгээрээ үлдэнэ. Авах юм бол ердийн журмаар энэ тогтоол үйлчлэх л ийм л зарчим үйлчилнэ. Түүнээс биш Ерөнхийлөгчийн хоригийн асуудалд бүрэн эрхэд халдсан уу, үгүй юү гэдэг цаана нь яг энэ дээр бол логикийн хувьд хууль зүйн техникийн хувьд боломжгүй болчихоод байна. Зарим гишүүд холбож тайлбарлаад байна. Тэр төсвийн хуультай.

Тэгэхээр яг энэ хориг тавих процесс хэлэлцэх энэ арга зүйн талаасаа яах юм бол холбох ямар ч боломжгүй байхгүй юу. Яг л тухайлан хууль дээрээ тавьсан асуудлаа ярина. Тэгэхээр энийг гишүүд бодолцож бас энэ Төсвийн байнгын хорооны тавьж байгаа энэ агуулгаар нь хүлээж авъя гэсэн ийм саналтай байна.

Ер нь зүгээр цаашдаа Ерөнхийлөгчийн энэ хоригийн асуудал, хоригийн хүрээ хязгаарыг бас тодорхой болгох энэ зүй ёсны шаардлага үүгээр бас харагдаж байна л гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн үг хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ тогтоол батлагдаж байх үед бас Монгол Улсын Ерөнхий сайдаас өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа энэ хууль, эрх зүйн хүрээнд ашигт малтмал тэр дундаа алт олборлож байгаа энэ үйл явц хуулийн дагуу байж чадаж байгаа юу, үгүй юү. Бидэнд алт хэрэгтэй байгаа.

Гэхдээ байгаа, гаргаж байгаа алтаа зөв хянаж чадаж байгаа юу, үгүй юү гэдэг асуултыг бас асууж байсан.

Тэгээд өнөөдөр энэ алт аянтай холбогдуулаад Монгол Улсын алттай гэж байгаа тэр уул устай тэр олон газруудад юу болж байгаа вэ гэдгийг сошиалаар та бүхэн харж байгаа байх. Монгол Улсад энэ урт нэртэй хууль гэж бас хууль хэрэгжээд нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Үнэхээр энэ хууль өнөөдөр ер нь хэрэгжиж байна уу, үгүй юү гэдэг дээр ер нь хэн анхаарал хандуулах ёстой юм бэ? Төрийн байгууллага нь очоод лацаддаг, лацдахад нь лацыг нь эвдээд алтыг нь ухаад сууж байдаг ийм улс гэж байдаг юм уу? Тэгээд энэ дээр ер нь эхлээд миний хэлсэн санаа бол бид алтаа ашиглаж болно. Эхлээд одоо байгаагаа цэгцлэхгүй бол болохгүй ээ л гэж тухайн үед хэлж байсан. Тэр үг өнөөдөр бодит байдал дээр ямар байгааг та бүхэн бэлхнээ бас би харж байгаа болов уу гэж ингэж бас бодож байгаа. Тийм учраас би энэ Ерөнхийлөгчийн энэ хоригийг хууль, эрх зүйн хүрээнд олон учир холбогдлууд байгаа гэлээ. Гэхдээ би ерөнхий агуулгаар нь бол дэмжих нь зүйтэй гэж ингэж бас хэлж байгаа юм.

Хоёрдугаарт яагаад би дэмжих гээд байгаагийн шалтгааны хоёрт бол Монгол Улс өнөөдөр ер нь тушааж байгаа, олборлож байгаа алтаа бүрэн гүйцэт Монголбанкандаа авч чадаж байгаа юу, үгүй юү гэдэг чинь бас өөрөө эргэлзээтэй. Тоо худлаа хэлдэггүй гэж ярьдаг. КОВИД-ын үед бүх юм хаалттай байхад тушааж байсан алтны хэмжээ өнөөдрийн алтны хэмжээ хоёрын хооронд тэнгэр, газар шиг зөрүүтэй болчихсон. Тэгэхээр үндсэн энэ 2 асуудлаа шийдчихэж байж энэ Монгол Улсын үүц болсон энэ асуудлуудаа энэ ордууд руугаа бид дараа бүх юмаа цэгцэлсний дараа ярих ёстой юм л гэж би ингэж харж байгаа.

Тэгээд энэ манай энэ Хэнтийн Батширээт, Биндэрт байгаа энэ Гутайн давааны асуудал. Энэ дээр Байгаль орчны сайд өөдөөс хараад сууж байна. Та бас энэ Сангийн яамныхан бас анхаараач. Сая би чуулганы өмнө очоод Ганхүлэг гишүүн бид 2 очоод уулзахад энэ алтны ордыг хамгаалах ёстой хүмүүс нь байгаль хамгаалагч нь мотоциклдоо хийх бензин байхгүй. Энэ 7 сарын төсвийн хэмнэлтээр бүх юмыг нь татаад авчихсан. Сумын колонкод өчнөөн өртэй болчихсон, өмсөх хувцас байхгүй үгүй ээ ийм байдалтай байна лээ шүү. Би энийг бол бүүр зориуд бас хэлчихье гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ алттай холбоотой энэ асуудалд. Дараагийн нэг юм бол энэ хүмүүс ажлаа хийгээд тодорхой сэжиг бүхий тохиолдлуудыг илрүүлээд энэ Экологийн цагдаагийн алба руу хүргүүлдэг. Эргээд ямар ч хариу байхгүй. Ард иргэд ч байхгүй, байгууллагад нь ч байхгүй. Тэгээд эндээс ямар хардалт үүсээд байна гэхээр хамгаалж байгаа нэртэй ухаад байгаа юм биш биз дээ? Нөгөө хүрээнээс хөөгдсөн гамин бороон замдаа түйвээж байна гэдэг шиг энэ Сэлэнгэ энэ хавиас хөөгдсөн нөхдүүд ийшээ очоод бас ухаж төнхчих гээд байх зовлонтой юм билээ.

Х.Булгантуяа: Гишүүн, Идэрбат гишүүн үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Энэ Улсын Их Хурлын 85 дугаар тогтоол Ерөнхийлөгчийн хориг бол хууль гаргаж хуу дээрэмдэнэ гэсэн үг болоод өмнөх парламентын авлигын түүхийг яг бодитоор харуулж өгсөн жишээ. Алт-3 аяныг

хэрэгжүүлэх хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийг улсын хамгаалалтад авсан Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоолыг яаралтай өөрчилж оруулж ирэхийг Улсын Их Хурал Засгийн газарт өгч байгаа чиглэл, үүрэг байгаа байхгүй юу. Тогтоолын төслийг яаралтайгаар шүү оруулж ир гэж байгаа юм. Энэ дээр нь Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан.

47 дугаар тогтоол гэдэг бол Ноён уулыг тэр чигээр нь хамгаалалтад авсан тогтоол байдаг. 46 дугаар тогтоол бол Гутайн даваа Хөмүүл голын их ай сав газар, Байгалийн цогцолборт газрыг хамгаалалтад авсан ийм 2 тогтоолыг нууцаар гишүүдийг анхаарлаа хандуулаагүй үед өөрчлөх гэж оролдлоо л доо. Яаж өөрчилсөн бэ гэхээр одоо гишүүд гайхаад байгаа байхгүй юу. Энэ асуудлыг хэн оруулаад ирчихсэн юм бэ? Засгийн газар оруулж ирээгүй, салбарын сайд нь оруулж ирээгүй бараг мэдэх хүн байхгүй. Энэ нь ажлын хэсэг дээр гэнэт л санал гаргаад ажлын хэсгийн саналыг холбогдох мэргэжлийн Байнгын хороонд оруулсан. Байнгын хороо саналыг дэмжээгүй. Энийг яаж босгодог вэ гэхээр гишүүдийг олон асуудал хэлэлцсэний дараа анхаарал суларсан, зарим гишүүд гараад явсан үед дэмжээгүй саналыг дэмжье гэж оруулж ирдэг юм байна.

Тэгэхээр танхимд байхгүй гишүүд дэмжээгүйгээр орно. Ингээд энэ асуудал нь босчихдог энэ бол нөгөө улс төрийн авлигын инженерчлэл байхгүй юу. Өмнөх парламентууд яг ингэж явж ирсэн. Энийг анх удаагаа нүүр тулж харлаа. Тэгэхээр бид нар энэ улс төрийн авлигын инженерчлэлийг дэмжиж болохгүй ээ. Угаасаа манай хуульд байна. Алсын хараа-2050-д байна тусгай хамгаалалттай газар нутгийг 40 хувьд хүргэх ёстой олон улсын гэрээ, конвенцод манай улс нэгдчихсэн байна.

Тэгэхээр нөхдүүд дахиж ингэж анхаарал суларсан үед үдээс хойшоо Улсын Их Хурлын нэгдсэн чуулган руу хулгайн замаар авлига авсан байж болзошгүй ийм хулгайн хуулийн тогтоолыг ямар нэгэн зааврыг оруулж ирмээргүй байна. Бид өмнөх парламентын энэ гашуун түүхийг давтмааргүй байна. Хууль гаргаад л хуу хамчихдаг, хулгайлчихдаг, авлига аваад л сэмхэн шургуулдаг. Энийг манай 126 гишүүн их анхааралтай байхгүй бол бид нар анхныхаа удаа яг улаан нүүрээрээ тулсан. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг бид хүлээж авах ёстой. Хоёр хоригийг хоёуланг нь хүлээж авах ёстой. Үүнээс цаашаа авлигын энэ инженерчлэлийг таслан зогсоох ёстой гэж бодож байна. Тийм учраас та бүхэн өнөөдөр одоо бас танхимд ихэнх гишүүд байхгүй л байна. Дахиад л унагаачих вий дээ. Тэгээд энэ Ерөнхийлөгчийн хоригийг дэмжих байх гэж.../минут дуусав./

Х.Булгантуяа: Хассуурийн Ганхуяг Төсвийн байнгын хорооны дарга.

Х.Ганхуяг: Тийм. Мөнхбаясгалан гишүүний асуудлыг дэмжиж байгаа юм. Тэр үндсэн тэр юу билээ. Хилийн бүсээс гаргах тэр нөгөө тусгай хамгаалалттай газраас гаргах асуудлыг бол дэмжиж байгаа. Төсвийн байнгын хороон дээр бол тухайн асуудлыг бол дэмжиж Байнгын хорооны гишүүдэд санал өгсөн байгаа. Яах вэ 2 дахь асуудал дээр харин жоохон асуудал байгаад байгаа юм.

Яагаад гэхээр яг тогтоол дээр хугацаа заасан зүйл, заалт байхгүй байна. Тэр нь бол юу гэж заасан бэ гэхээр Төсвийн хууль мөрдөж эхэлсэн өдрөөс энэ тэр тогтоол хүчинтэй болно гээд. 85 дугаар тогтоол хоёулаа одоо 7 сарын 9-ний өдөр батлагдсан юм байгаа юм. Яагаад тэр 2 дахь асуудал дээр нь хоригийг нь хүлээж

авахгүй гээд байгаа вэ гэхээр үндсэндээ тэр тогтоол дээр хугацаа байхгүй, тавих байсан бол төсвийн тодотгол дээр л хориг тавих байсан юм. Төсвийн тодотголын хугацаан дээр. Төсвийн тодотголын хугацаан дээр л хугацаа байгаа юм 7 сарын 9 гэдэг өдөр.

Тэгэхээр бид нар өнөөдөр тогтоол дээр хугацаа ярихаар өөрөө жоохон өрөөсгөл болчихоод байгаа юм. Хууль зүйн хувьд, хэрэглээний хувьд буруу болчихсон гэсэн үг. Нэг ёсондоо бид нар энэ тогтоолын хугацаан дээр хориг хүлээгээд авчихаар төсвийн тодотгол өөрөө хүчин төгөлдөр болох хугацаа нь өөрөө тодорхой бус болчихож байгаа гэсэн үг. Өнөөдрийг хүртэл Засгийн газрын зарцуулсан мөнгө төгрөг нь яг хуулийн дагуу зарцуулсан эсэх нь бас эргэлзээтэй болж байгаа гэсэн үг. Хууль зүйн хувьд өөрөө энэ буруу болчихоод байгаа юм. Тийм учраас төсвийн тодотголыг хүчин төгөлдөр байлгах үүднээс бид нар 2 дахь асуудлыг нь хүлээж аваагүй юм шүү. Энийг бас та бүхэн ойлгоорой гээд.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Хэлсэн шүү дээ. Алт-3 тогтоол чинь буруу юм биш үү гэж хэлсэн шүү дээ. Эцсийн найруулга сонсоход хүртэл хэлсэн. Хүний гараар могой барих гэж байгаад могойн хорондоо хордож байгаа Засгийн газар л байхгүй юу. Хаанаас оруулж ирсэн юм? Нэг их ажлын хэсэг дээр оруулаад ирчихсэн юм шиг худлаа ярихаа больё. Өчнөөн л яригдсан шүү дээ. Төсвийн орлого яачихсан байгаа юм, одоо эдийн засаг ямар байгаа юм. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 25 оны эхний 7 сард 1.3 их наядын төгрөгийн алдагдалтай байгаа гээд Статистикийн хороо зарлачихсан шүү дээ. Хэцүү байгаа, орлого хэцүү байгаа. Цаашдаа ч гэсэн хэцүү. Нүүрсний борлуулалт бүр хүндэрч байгаа.

Тэгээд алтны үнэ өсөж байгаа дээр Алт-3 хөтөлбөрийг явуулах хэрэгтэй байна гээд л яригдсан шүү дээ. Тэгээд Засгийн газар өөрт байгаа бүрэн эрхийнхээ дагуу асуудлаа оруулаад ирчихгүй худлаа нэг шахуулсан болж Их Хуралд асуудлыг нялзааж байгаа байхгүй юу. Өмнө Алтангэрэл сайдын бас нэг тогтоол байсан. Хянан шалгахыг Засгийн газарт бид нарт даалгаад өгөөч ээ гээд. Тэгээд өөрсдөө өөрсдийнхөө ажлаа хий л дээ. Яагаад Улсын Их Хурлаар могой бариулах гээд байгаа юм. Ерөнхийлөгчийн хоригийг авах нь зүйтэй.

Гэхдээ 2 заалтаар нь тус тусад нь явж болж байгаа эсэхийг дахиж тодруулмаар байна. Энэ тогтоолыг Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн нь яг юу нь зөрчихөөд байгаа юм Үндсэн хуулийг? Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр болгосон нь буруу байгаа юм уу? Ерөнхийлөгчийн Тамгын газар ч гэсэн аливаа асуудалдаа жоохон наанатай цаанатай хандахгүй бол одоо бид нар ингээд Алт-3-ыг хоригийг нь авсангүй гээд асуудалд орох уу? Урьд өмнө нь баталсан хуулиуд яах юм болж байна? Цаашид үүсэх прецедент нь яах юм болж байна. Алт-3-ын цаад агуулгыг нь хоригийг нь тавьж болж байна ойлгож байна. Тэрийг бол хүлээж авч болж байна.

Харин 2 дахь заалт зүгээр албаар л Үндсэн хуулийн зөрчил рүү мушгиж оруулах гэж байгаа юм шиг л ийм л ийм асуудал харагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр гишүүд ээ бас наанатай цаанатай хандаж, асуудалд яг үнэн мөнөөр нь

хэдүүлээ бас харахгүй бол дараа дараагийн ажилд маань саад тотгор болохоор байна шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар хэлэлцэж байна. Гадаадын валютын нөөцийг нэмэгдүүлэх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлнэ гэсэн зорилгоор улсын тусгай хамгаалалтад байгаа байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёл шинжлэх ухаан, археологийн түүхийн дурсгалт газраас авч, алт олборлохыг бол дэмжихгүй. Алттай холбоотой олон үе шаттай ажиллагаанууд Монгол Улсад явагдсан. Тэгээд уул уурхайдаа иргэд нь итгэхээ байчихсан яг одоо хэлэлцүүлэг болоод л байж байна. Олгоод байдаг. Тэгэхээр өмнө олгосон “ХА” буюу нөгөө зөвшөөрлүүд дээрээ ажиллах, хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлэх, ашиглалтын энэ эрхүүдийг нь нээж өгөх энэ чиглэл дээрээ түлхүү ажиллах нь зөв байх.

Төсвийн байнгын хорооны даргаас нэг зүйл тодруулах гэсэн юм. Алт олборлолт түүний эдийн засгийн үр өгөөж өнөөдөр, одоо төсвийн хэдэн хувийг эзэлж байгаа вэ Ганхуяг дарга аа? Ганхуяг дарга аа, Төсвийн байнгын хорооны даргаас би тодруулж байгаа юм. Төсвийн байнгын хорооны дарга танаас юм асуугаад байгаа юм. Тодруулж байгаа юм шүү. Алт олборлолт түүний эдийн засгийн үр өгөөж өнөөдөр төсвийн хэдэн хувийг бүрдүүлж байгаа вэ? Яг төсөв дээр тийм энэ Алт-3 дугаар хөтөлбөрийг явуулахгүйгээр тийм хүндрэл үүсэх үү? Энэ дээр та тодруулга хэлж өгөөч.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Монгол Улсын эдийн засагт бол нөгөө эрдэс баялгаас гол төсөв бүрдүүлэгч ер нь минералууд бол зэс, төмөр, төмрийн хүдэр, нүүрс байгаа. Алтны хувьд бол ямар ач холбогдолтой байдаг вэ гэхээр бид нарын нөгөө валютын нөөцийг бүрдүүлдэг, төгрөгийн ханшийг сулруулахгүй байхад онцгой үүрэг гүйцэтгэдэг байгаа. Яг төсөвт үзүүлэх юу нь бол харьцангуй бага байдаг, нөлөөлөл нь бол бага байдаг. Тэгээд яах вэ бид нар бол энэ жил 20 тонн алт авна гэж төлөвлөсөн боловч өнөөдрийн байдлаар 10 хүрэхгүй тонн олборлож байна. Ирэх жил бол төсвийн хүрээ болон төсвийн хүрээнд тэр тусад нь харвал дахиад л 20 тонн олборлоно л гэсэн байдлаар орж ирсэн байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Тэгэхээр Ерөнхийлөгчийн хоригийг бол хүлээж авах нь зүйтэй гэдэг дээр бас би санал нэг байна. Тэгээд саяхан би өнгөрсөн 2, 3 хоног бас өөрийн сонгогдсон тойрогтоо ажиллалаа. Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Мандах сум, Хөвсгөл сум, Сайхандулаан гээд 5 сумд ажилласан, иргэдтэй уулзлаа. Тэнд бас үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн төслүүдтэй бас танилцаж явлаа. Тэгээд эндээс нэг зүйл харагдаж байгаа юм. Бид нар ер нь хаанаас нь ухах юм бэ, аль хэсгээс нь газар нутгийнхаа уул уурхайгаа ашиглах юм бэ, ямар хэсгийг нь үлдээх юм бэ гэдэг ер нь бодлого байхгүй бол илэрсэн

болгоныг, нөөцтэй болгоныг л ухна гээд байдаг бол бас буруу юм. Яг Дорноговь аймагт бол тодорхой харагдаж байгаа юм.

Жишээ нь, Хатанбулаг, Мандах сумын нутгийн зааг, Хөвсгөл сум 3-ын зааг дээр гэхэд л 6 нүүрсний уурхай зэрэг ажиллаж байна шүү дээ. Түүний нэг нь бол яг Мандах сумын тахидаг хайрхных нь ёроолоос ухаад ингээд л байж байх жишээтэй. Тэгэхээр иргэд асар уул уурхайг үзэн ядах ийм сэтгэхүйтэй болчихсон. Нэг талаараа иргэд цалин хөлсөө нэмнэ, тэтгэврийг нэм гэж байгаа мөртөө нөгөө талаар уул уурхайгаа эсэргүүцэж байгаа. Өнөөдөр бидэнд орлого олж байгаа ганц салбар, экспорт хийж байгаа ганц салбар бол уул уурхайн салбар байх.

Тэгэхээр өнөөдөр иргэд сумын удирдлагуудтай уулзаж байхад тэнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай орон нутагт ямар ч үр өгөөж байхгүй. Харин бүүр эсрэгээрээ энэ байгаль орчныг сүйтгэж байгаа. Уг нь Засгийн газрын тогтоолтой уул уурхайн бүтээгдэхүүнийг бол хатуу хучилттай замаар зөөх ёстой гэж. Тэнд хатуу хучилттай замаар зөөж байгаа уурхай нэг ч алга. Байгаль орчин сүйтгэж шороо тоос босгоод ингээд явж байгаа.

Тухайлбал, Хатанбулаг сумыг өөрийгөө санхүүжүүлдэг болсон гээд төсвөөс ингээд үүрэг даалгавар өгсөн. Өнөөдөр тэр сум сургуулийн хүрэлцээ, цэцэрлэгийн хүрэлцээ байхгүй. Төвийн нэгдсэн халаалт, сүлжээ, инженерийн шугамд сайн холбогдож чадаагүй олон сум тэр баруун талд байж байгаа. Бүгдийг нь Төсвийн хуулиараа дээш нь татаад орж байгаа орлогуудыг нь аваад өөрт нь үлдээж байгаа төсөв гэж байхгүй. Иргэд нь Үндсэн хуулиар заасан тэр эрүүл орчинд амьдрах эрх нь зөрчигдчихсэн, сум нь хөгжилгүй тэгээд ийм нөхцөлд үнэндээ цаашаа уул уурхайгаа дэмжээд явна гэдэг бол хэцүү юм байна.

Тийм учраас бид нар бас газрын доор юу байгаагаа эхэлж сайн мэдэх хэрэгтэй эрэл хайгуулын ажлаа эрчимжүүлээд. Тэгээд дараа нь дэс дараатайгаа эрэмбээр эхлээд юуг нь ашиглах вэ, дэлхийн зах зээл дээр ямар эрдэс, ашигт малтмал нь үнэтэй байна вэ гэдгээ тогтоож байж цаашаа ашиглах тухай ярихгүй бол өнөөдөр илэрц гарсан бүхнийг тусгай хамгаалалттай ч байсан, хамгаалалтгүй ч байсан ухаад байна гэж.../минут дуусав./

Х.Булгантуяа: Наранбаатар гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд. Төсвийн байнгын хорооноос орж ирсэн Ерөнхийлөгчийн хоригийг дэмжих нь зөв байх гэж ингэж үзэж байна. Гэхдээ би бол зүгээр зарчмын зүйл хэлэх гэсэн юм. Ер нь алт ч бай, мөнгө ч бай, нүүрс ч бай, байгалийн баялаг элс, хайрга гээд эдгээр асуудлыг, зөвшөөрлийг дэндүү төвлөрүүлэн татчихсан. Тэгээд манай улсад болохгүй байгаа зүйлийн эх сурвалжийг оношийг ол гэвэл бүх зүйлийг төвлөрүүлэн татсантай холбоотой гэж ойлгож байгаа. Одоо ингээд тэр Байнгын хороон дээр хэлэлцүүлэг болж байна. Халзан Бүрэгтэйн асуудлыг 2000 гаруй километр газраас Төрийн ордонд аваад ирсэн. Тэгээд энд Халзан Бүрэгтэйнгээ ч мэдэхгүй, Ховдоо ч мэдэхгүй, зүүн, баруунаа ч мэдэхгүй хүмүүс энд цэцэрхэж ярьдаг.

Яагаад вэ гэхлээр зөвшөөрлийг энд өгч байгаа, тэнд юуг нь ч мэдэхгүй хүмүүс энэ зүгээр л нөгөө сохор нохой дүйвээнээр гэж хаана шуугиан дэгдэж

байна вэ тэр рүү л зүгээр хошуурч ингэж эсвэл зөвшөөрөл өгдөг, эсвэл эсэргүүцдэг ийм нөхцөл байдлаасаа салах ёстой. Энэ уул уурхайтай холбоотой асуудал шуугиан дэгдээж байгаа асуудал бол Мэргэжлийн хяналтын газрыг тараасантай бол бас шууд холбоотой. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдлийг шууд авсантай холбоотой. Тэнд 2000 км-т, 3000 км-т, 800км-т байгаа асуудлыг тэр нутгийн багийн ИНХ гэж мундаг том үндсэн хуулийн олгогдсон эрхтэй газар байж байгаа. Сумын иргэдээс сайн, муу хэлэгдээд сонгогдсон Иргэдийн хурал гэж байж байгаа. Аймгийн нийт нутаг дэвсгэрийг мэддэг, ойлгодог, судалдаг ард иргэдээсээ арай л энэ л биднийг зарчихгүй байх, энэ л бид нарыг худалдчихгүй байх, энэ зөв юм хийж өгөх байх гэсэн хүмүүс байж байгаа. Энэ бүх зүйлүүдийг хуу хамаад энэ бор байшинд оруулаад ингээд бүх зүйлийг 126-гаар л үүрэг өгсөн юм шиг, 126-гаар шийдвэрлүүлсэн юм шиг нүүрэндээ маск зүүгээд ингээд сайн, муу зүйл хийдэг асуудлаа болих хэрэгтэй юм л гэж ингэж үзэж байгаа юм.

Жишээлэх юм бол нөгөө талд нь уул уурхайг хамгаалъя гээд ингээд боллоо гэхэд нөгөө талд нь зам тавья, байшин барья гэнгүүт элсний зөвшөөрөл авах, алтны зөвшөөрөл авахаас илүү хэцүү болчихсон байна шүү дээ. Хайрганы зөвшөөрөл авах нь алтны зөвшөөрөл авахаас хэцүү болчихсон байна. Тэгээд элсгүй, усгүй, хайргагүй юм бол ямар бүтээн байгуулалт хийх юм бэ. Тэгэхлээр би бол асуудлын мөн чанар нь энэ цаашид ийм хоригууд тавигдах байх, Их Хурлаар болсон, болоогүй зүйлүүд орж ирэх байх. Энэ асуудлаа дунд шатад өгөөч ээ, анхан шатад нь өгөөч ээ, тэр ард иргэд чинь тэмтэрч үзээд, харж үзээд, долоож үзээд, хамтарч ажиллаж болно л гэвэл тэгээд л өөрсдөө хяналтаа тавиад л явна шүү дээ. Тэгэхгүйгээр бүх зүйлийг энэ Төрийн ордонд татаж авчирснаас л бүх асуудал, төсөв ч бай, уул уурхай ч бай.../минут дуусав./

Х.Булгантуяа: Батсуурь гишүүн нэмж 1 минут.

Ж.Батсуурь: Тийм асуудлынхаа бид нар оношийг нь тавихгүй. Тэгээд нэг асуудал ороод ирэнгүүт тэр асуудал хориг байна уу, юу байна уу үүнийгээ дагаад, маргаад, мэтгэлцээд, тэгээд олс таталцаж байгаа хүүхдүүд шиг чинийх зөв, минийх зөв гэнгүүт оношоо тавиагч дээ. Бүх зүйл чинь төржчихсөн байна, төвлөрчихсөн байна, төсөвжисөн байна, тэгээд эдийн засгийг тэлъе, орон нутагт нь эрх мэдлийг нь өгъе гэвэл энэ бүх зүйлээ тэр энэ төрийн бахинаас нь салгаач ээ, гав гинжнээс нь салгаач дээ. Хяналтыг нь мэддэг, чаддаг тэр анхан шатынх нь хүмүүст өгөөч дээ. Тэгэхгүйгээр бид нар бол бүх зүйлийг төсвийг ч тэр, уул уурхайг ч тэр, бүтээн байгуулалтыг ч тэр, чөлөөт эдийн засаг, хувийн хэвшлийг ч тэр эндээс дэмжинэ гэж юу байдаг юм бэ? Эрхийг нь өгөөд л зүгээр тэр хяналтыг нь ард иргэдэд нь давсан хяналтыг нь төрийн байгууллага нь хянадаг л ийм тогтолцоо руу ормоор байна л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа дарга.

Х.Булгантуяа: Батсуурь гишүүн үг хэллээ.

Тамгын газрынхан бас анхаараадхаарай. Одоо Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан Халзан Бүрэгтэйн орд газрын ашиглалт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах ерөнхий хяналтын сонсгол “Их эзэн Чингис хаан” танхимд өглөөнөөс хойш ярьж байгаа. Одоо 9 хүн асуулт асууж, үг хэлээд ингээд санал хураалт явагдахаар байна.

Дээрээс нь нэмээд Төсвийн байнгын хороо мөн төсвийн хөрөнгө оруулалтын талаарх хэлэлцүүлгийг бас зохион байгуулж байгаа юм байна. Тэгэхээр нэлээн олон гишүүн чуулганы танхимд байхгүй байгаад байгаа юм. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн үзэл санаатай олон гишүүд бас санал хураалтаас аягүй бол хоцорчхож магадгүй байгаа учраас тэр үеэр нь болохгүй бол сонсголыг түр завсарлуулж байгаад санал хураалтыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын Тамгын газрын ажлын хэсгүүд анхаараарай. Түрүүн бас Мөнхбаясгалан гишүүн бас хэлж байсан.

Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Алт-3 аяныг хэрэгжүүлэхтэй холбоог хэсэгчилсэн хоригийг хүлээж авах нь зөв гэж бодож байгаа. Энэнтэй холбоотой, яг энэ асуудлыг орж ирсэнтэй холбоотойгоор тодруулж асуух асуулт байна. Тэгээд энэ түрүүн бас танилцуулга дээр ч гарсан олон улсын гэрээ, конвенцтой холбоотой асуудлууд байгаа. Тэгэхээр яг ямар олон улсын гэрээ, конвенц нэгдсэн нь жишээлбэл энэ асуудал зөрчилдөж байгаа вэ? Тэр талаар тайлбар хийж өгөөч.

Тэгэхээр миний ойлгосноор бол угаасаа олон улсын конвенцоороо бид нар энийг батлах боломжгүй ийм зүйл байгаа гэж харагдаад байгаа. Тэгэхээр яг хуулиасаа хайхаар яг аль конвенц нь гэдэг нь бас тодорхой тийм тайлбар орж ирээгүй байна л даа. Энэ талаар тодруулга өгөөч.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг.

Х.Ганхуяг: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Монгол Улс 2022 оны 12 дугаар сард дэлхийн 190 гаруй улсын хамтарсан нэгдэж орсон Күньмин Монреалийн дэлхийн биологийн олон янзын байдлын хүрээний 30, 30 санаачилгад нэгдэж орсон байдаг. Тэрүүгээр бид нар 2030 он гэхэд нийт газар нутгийнхаа 30 хувийг тусгай хамгаалалттай газар болгох, мөн Алсын хараа-2050-д бид нар юу гэж туссан бэ гэхээр 2050 он гэхэд бид нар газар нутгийнхаа 35 хувийг тусгай хамгаалалттай газар болгож тэлэх ийм үүрэг хүлээсэн байгаа юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улс нийт нутаг дэвсгэрийнхээ 21 хувийг, 21 хувь буюу 32.8 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад авсан байна.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Энэ конвенц маань нөгөө Богд уултай холбоотой асуудал яригддаг шүү дээ. Тэгэхээр энэ бас яг Богд уулын асуудалтай, суурьшлын бүс болчихсонтой холбоотой асуудал бас яг энэ конвенцын хүрээнд зохицуулагдаж байгаа юу?

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны дарга Ганхуяг.

Х.Ганхуяг: Би энийг нэмж тодруулъя энэ санаачилга бол тусгай хамгаалалттай газар нутгийг байнга нэмэгдүүлэх, байгаа төрхөөр нь хадгалах ийм зорилго бүхий санаачилга байгаа юм. Тэгэхээр манай энэ Богд уулын асуудал бол нэг жоохон өөр болчхоод байгаа шүү дээ бид нар нөгөө суурьшмал бүс маань байнга тэлээд явчихсан асуудал бий. Тэгээд тэр дээр бол миний буруу санаагүй бол 2023 онд байна уу, 24 онд заагийг нь дахин шинэчлэн тогтоосон байдаг.

Нийслэлийн газар нутгийг нэмж газар нутаг олох байдлаар заагийг нь шинэчлэн тогтоосон байдаг. Тэгээд энийг тодруулаад танд бас дараа нь мэдээллийг олж өгье.

Х.Булгантуяа: Уур амьсгал, байгаль орчны сайд Батын Батбаатар.

Б.Батбаатар: Ерөнхийлөгчийн хориг тавигдсан нь зөв, дэмжиж байгаа. Хориг тавьж өгсөн Ерөнхийлөгчид бас талархал илэрхийлье. Хаврын чуулганы хаалтын үеэр Улсын Их Хурал ийм тогтоол гаргаж болохгүй ээ гээд энэ чуулганы танхимд хэлээд үнэндээ саналын дүн бол гүйцэж чадаагүй тогтоол гарсан.

Байгаль хамгаалал гэдэг бол ер нь олон хүнтэй муудалцах салбар юм шиг байна. Орон нутаг, төрсөн нутаг орондоо амарч зугаалж яваа хүнтэй хүртэл муудалцах шаардлага байгаль хамгаалагчдад гардаг. Хог хаячих вий, түймэр тавьчих вий, амьтан, ургамал сүйтгэх вий гээд, Улсын Их Хурлын түвшинд, Засгийн газарт ч гэсэн олон хүнтэй муудалцах шаардлага Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хувьд тулгарч байгаа. Засгийн газар дотор ч Засгийн газрын гишүүдтэйгээ хангалттай сайдаж, муудаж байгаа. Улс төрийн шалтгаан, эрх ашгийн шалтгаан, бусад шалтгаанаар Улсын Их Хурал, Засгийн газар, Засаг дарга албан тушаалтнуудтай бол их муудалцах хэрэг гарах юм байна. Тийм болохоор сая үг хэлсэн, хоригийг дэмжсэн бүх гишүүддээ дахин талархал илэрхийлье. Энэ хоригийг хүлээж авахгүй бол олон улсын өмнө Күньюмин Монреалийн 30,30 санаачилгад нэгдсэний хувьд Монгол Улс ичгэвтэр байдалд орно. Ирэх онд бид нар 330 хоногийн дараа Цөлжилтийн эсрэг талуудын 17 дугаар бага хурлыг хийх гээд Монгол Улс зохион байгуулах гээд сууж байгаа, Үндэсний хороо нь ажиллаж байгаа.

1992 онд Монгол Улс дэлхийд анх удаагаа газар нутгийнхаа 30 хувийг тусгай хамгаалалтад авна гэдгийг зарлаж байсан. Олон улс орны төлөөлөгчид Монголыг шоолж байсан. Одоо дэлхий нийтээрээ хуурай болон усан газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалтад авах нь зүйтэй гэдэг энэ 30,30 санаачилгад 190 гаруй улсууд нэгдчихсэн байж байна. Энэ санаачлагч анхных нь улс орон тусгай хамгаалалттай газар нутгаасаа алт олборлох зөвшөөрлийг өгвөл олон улсын өмнө бид бол нэр нүүрээ алдахаасаа илүү худалч гэдгээрээ цоллогдог болно. Тусгай хамгаалалттай газруудын хилийн цэс хязгаар бусад зүйлийг оруулж ирэхээр 8 удаа Хэрэг эрхлэх газарт оруулсан боловч энэ батлагдаж ор.../минут дуусав./

Х.Булгантуяа: Яг энийг хавар хэлэлцэж байхад бас Батбаатар сайд бас хэлж байсан Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр миний бие ч гэсэн бас бид олон улсын гэрээ, конвенцоор тусгай хамгаалалтынхаа газар нутгийг нэмэгдүүлэх ёстой болохоос биш алтны олборлолтыг нэмье, төсвийн орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай байна гээд зүгээр Улсын Их Хурлын тогтоолыг дагаад энийг бол тусгай хамгаалалтын газраас гаргах бол хэцүү.

Хэрвээ тийм байгаа бол энэ чинь олон улсын конвенц бол яг хууль тогтоомжтой адилхан хэрэгждэг учраас энийг хэрвээ тийм бол холбогдох Засгийн газрын сайд нь энэ асуудлыг бүүр оруулж ирж яг хууль тогтоомжтой адилхан хэлэлцүүлэх энэ процессыг бол явуулах ёстой гэдэг байр суурийг бас илэрхийлж байсан. Тухайн үед бас Батын Батбаатар сайд бас яг энэ үгийг, манай

Мөнхбаясгалан гишүүн бас яг тэгж дэмжиж өнгөрсөн хаврын чуулганаар бас хэлж байсан.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасан.

Л.Энхнасан: Сайн байцаана уу? Өдрийн мэнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэ “Алт-3 аян”-ыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд тавьсан хоригийг дэмжиж байгаа. Тэгэхдээ тодруулж асуух хэдэн зүйл байна. Ялангуяа энэ Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг илүү дэмжиж байна. Энэ тогтоолын 1 дэх заалтын 5 дахь заалт дээр хориг тавьсан байгаа. Тэгээд энэ дээр миний ойлгож байгаагаар тусгай хамгаалалттай бүсээс зарим газруудыг хэсэгчлэн гаргах гэж байна гэдэг үндэслэлээр энэ заалт дээр хориг тавьсан уу, эс үгүй бол энэ яаралтай горимоор өргөн мэдүүлэх гэж байна гэдэг энэ дээр хориг тавьсан байгаа юу энэ дээр бас тодруулж асууя.

Ялангуяа ер нь ХҮН нам бол энэ байгальд ээлтэй эдийн засгийг илүү дэмжих, ялангуяа аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч гээд энэ салбаруудыг илүү дэмжих бодлогыг баримталж байгаа. Тусгай хамгаалалттай газар нутгуудаас ялангуяа энэ жишээлбэл Говь-Алтай аймгийн энэ Нарансэвстэйн энэ боомтын орчимд, Хэнтий аймгийн Батширээт гээд энэ тус хэд хэзээ ч байгаль нь дахиж нөхөн сэргэгдэхгүй энэ баялаг бол сөргөөр нөлөөлөхөөр энэ эрсдэлтэй байгаад байгаа. Тэгэхлээр энэ газрууд ер нь тусгай хамгаалалтаас гаргахаар ингэж төлөвлөсөн байсан уу, энэ дээр ямар нэгэн мэдээлэл байна уу гэсэн асуулт байна.

Х.Булгантуяа: 4 номерын ажлын хэсгийн микрофон Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Үйлстөгөлдөр.

А.Үйлстөгөлдөр: Энхнасан гишүүнд баярлалаа. Тэгэхээр энэ 1.5 бүхэл тэр заалт нь тэр чигт нь л гэсэн үг үндсэндээ хориг тавьсан гээд. Энэ дээрээ таны яг дурдаж байна л даа. Холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах, тэгээд яаралтай өргөн мэдүүлэх гээд заасан байгаа. Тэгэхээр өөрчлөлт оруулах гэдэг үг нь өөрөө шууд санаа агуулаад байна л гэж байгаа юм. Өөрчлөлт оруулж ир ээ энэ дээр яах вэ нэмэлт, өөрчлөлт гэвэл бас нэг өөр бодож болно. Тэгээд шууд өөрчлөлт оруулаад яаралтай горимоор өргөн мэдүүл ээ гэхээр тусгай хамгаалалттай газар нутгаас заримыг нь гаргаач ээ, эсвэл бүүр ингээд өөрчлөөч ээ гэсэн санаа агуулж байна. Тэгэхээр энийг яг яаралтай өргөн мэдүүлэх, өөрчлөлт оруулах гэсэн энэ эдгээр заалтууд тантай санал нэг байна. Ингээд бүхэлд нь яг 5 дээр нь тавьсан гэж өгнө. Шууд санаа агуулсан гэж ойлгож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Гүйцэтгээд хариулах уу 4 номерын микрофон болчихсон уу? Гочоогийн Ганболд зөвлөх нэмж хариулъя 4 номерын микрофон.

Г.Ганболд: Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхийлөгч бол Алт-3 аяны орсон тогтоолыг Засгийн газраас оруулсан тогтоолын хэмжээнд бол бүрэн дэмжиж байгаа. Алтны нөөцийг нэмэгдүүлэх ёстой, валютын ханшийг барих ёстой гэдэг агуулгаар дэмжиж байгаа. Хамгийн гол нь Засгийн газраас өргөн барьсан тогтоолд энэ 5 дугаар заалтыг Улсын Их Хурлын ажлын хэсгээс оруулаад Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоолоор авсан тэр тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээнээс шууд хэлэлцүүлгийн явцад тодорхой ордуудыг ярьж

байсан л даа Эрээн Баавгайт, Гацуурт, Ноён уул гэсэн ийм 3 тусгай хамгаалалттай, зарим нь бол дархан цаазтай газраас газар чөлөөлж алт олборлох тухай асуудлууд яригдаж байсан учраас энэ асуудал дээр нь Ерөнхийлөгч Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийг зөрчиж байна уу гэж үзэж хориг тавьж байгаа юм. Тусгай хамгаалалттай газар нут.../минут дуусав./

Х.Булгантуяа: Ганболд гишүүний микрофоныг. Ганболд даргын, зөвлөхийн микрофоныг нэмж өгье.

Г.Ганболд: Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн 25.2-т Улсын Их Хурлын бүрэн эрх гээд байгаа. Энэ дээр тусгай хамгаалалттай газар нутгаас газар чөлөөлөх, нэмэгдүүлэх асуудал нь бол зөвхөн Засгийн газрын өргөн мэдүүлснээр л Их Хурал хэлэлцэх ийм заалттай байгаа. Тийм учраас түрүүн бас манай Сайнзориг гишүүний асуусан Улсын Их Хурлын хууль санаачлах эрхэд бол ерөөсөө халдаж хориг тавьсан зүйл огт байхгүй ээ. Улсын Их Хурал үнэхээр энэ асуудлыг Их Хурлын хэмжээнд оруулаад явъя гэх юм бол Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийнхаа 25.2.2 дахь заалтыг өөрчлөөд энийг оруулаад явах бүрэн эрх нь байгаа. Тийм учраас хэлэлцүүлгийн явцад энэ асуудлууд хөндөгдөж байсан учраас тодорхой лицензүүдийг тусгай хамгаалалттай газар нутгаас чөлөөлж ашиглах гэж байна гэдэг агуулгаар энэ заалтад тодорхой хориг тавьж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг.

М.Ганхүлэг: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийлөгчийн хоригийн гол агуулгын хамгийн 1 дээр байгаа Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46, 47 дугаар тогтоолуудтай холбогдолтой асуудал дээр би бас саналаа хэлье. Агуулгын хүрээнд бол Ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж байгаа. Зарчмын хэд хэдэн зүйлүүдийг бас хэдүүлээ бас тохирч авах ийм шаардлагууд бас байна гэж харж байна. Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 3 тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг миний бие ахалж байгаа юм. 2019 оны 41 дүгээр тогтоолоор 17 газрыг, 2020 оны 46 дугаар тогтоолоор шинээр 9 газрыг, 2020 оны 47 дугаар тогтоолоор бол Ноён уул болон түүний хил, заагийг өргөтгөхтэй холбогдолтой асуудлыг үндсэндээ Улсын Их Хурлаар батлан гаргасан.

Гэтэл өнөөдрийг болтол 7 жилийн хугацаанд энэ тусгай хамгаалалттай газар нутгийн хил, заагтай холбогдолтой асуудлыг эцэслэн тогтоогоогүй байгаа. Энэ 3 тогтоол батлагдахын өмнө энэ тусгай хамгаалалттай газар нутгууд дээр зөрчилтэй, давхардсан 400 гаруй цэгүүд байсан. Өнөөдөр энэ тоо 2 дахин нэмэгдсэн байгаа юм. Их Хурал аль хэдийнээ бол шийдвэрээ гаргаад ингээд өгчихсөн.

Тэгэхээр үүнтэй холбогдолтой асуудал бас үүний цаана байгаа. Батлахгүй байх сонирхол бас үүний цаана байгаа. Өмнө энэ санаархал нь бол энэ Алт-3 хөтөлбөрийн саяын энэ тогтоолтой холбогдолтой бас орж ирж байгаа юм. Иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөллүүдтэй бид бүхэн уулзсан. Тэгээд одоо яах вэ гээд тэгсэн энэ 800 гаруй энэ цэг газрыг бид бүхэн буцаан авахын тулд энэ газрын суурь үнэлгээ 32 тэрбум төгрөгийн тухай асуудал хүртэл яригдаж байгаа. Тохиролцох, тохиролцохуй тухай асуудал яригдаж байгаа.

Тэгээд энэ мөнгийг гаргаж чадна, чадахгүй, буцааж авна, авахгүй гэдэг ийм маргаантай асуудал руу бол энэ 7 жил болсны дараа бас бид бүхэн орчихсон байгааг бас би Их Хурлын гишүүддээ бас сануулж хэлье. Засгийн газрын хувьд энэ асуудал дээр онцгой анхаарах энэ чиглэл дээр энэ ажлын хэсэг бас гол анхаарал хандуулж ажиллаж байгаа юм.

Тэгэхээр энэ асуудалтай холбогдолтой хэд хэдэн зүйлүүдийг илүү тодорхой болгох юм сан гэсэн ийм юу гэсэн юу саналтай байна аа? Яг энэ Алт-3 гэдэг Үндэсний хөдөлгөөнийг бол эсэргүүцээд байгаа юм бол огт байхгүй. Энэ бол эдийн засгийнхаа хувьд бол ач холбогдолтой гэдгийг бол дэмжиж байгаа. Үүн дээр тусгай хамгаалалттай энэ бүсүүд дээр орж байгаа энэ газруудтай холбогдолтой асуудлыг цаашдаа ер нь хөндөхгүй байвал яасан юм? 2030 он хүртэлх энэ олон улсын конвенцын энэ бодлогоо бид бүхэн бариад явах тал дээр гишүүд өнөөдөр байр сууриа тэр илэрхийлж байгаа шигээ адилхан нэг талдаа гарах нь зөв гэсэн хамгийн эхний зарчим байгаа юм.

Хоёр дахь нь хэрвээ саяын ярьж байгаа нэр бүхий энэ газруудтай холбогдолтой асуудлууд яг үүний цаана ямар ямар газрууд байсан юм бэ? Ялангуяа энэ Гутаан даваа асуудал тодорхой энэ Ноён уултай холбогдолтой асуудлуудын бас

Х.Булгантуяа: Ганхүлэг гишүүн нэмж 1 минут.

М.Ганхүлэг: Холбогдолтой захиргаануудтай бас уулзалтуудыг бас зохион байгуулсан. Тэгэхээр энэ мэдээллүүдийг илүү дэлгэрүүлээд сая зөвлөх маань бас өгч байна. Бусад энд төслийг бэлдсэн Төсвийн байнгын хороон дээр байх юм уу, яг хаанаас байсан юм яг тэр үүний цаана ямар газруудыг эцсэндээ оруулъя гэж бодож байсан бэ гэдгийг нэг ил болгоод цаашдаа энэ асуудлууд бол яригдахгүй ээ гэдэг ийм байдал руу бас орох нь зөв байна.

Хоёр дахь нь тусгай хамгаалалтад оруулах нэг хэрэг байна. Оруулсан газраа баталгаажуулж авах нэг хэрэг байна. Дахиад тэр газрууд дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа тэрхүү захиргаагаа дэмжихтэй холбогдолтой асуудлууд байна. Тэгэхээр энэ цогц асуудлуудыг ер нь цогцоор нь харж энэ тодорхой 30, 30 хүчин зорилгоо хангах, уул уурхайгаа болон байгаль энэ хамгааллын энэ зарчмуудаа энэ 2 талд нь нэг тийм нэгдсэн ойлголттой болгох энэ чиглэлийн агуулгуудыг илүү нарийвчлах.../минут дуусав./

Х.Булгантуяа: 4 номерын микрофон Ганболд зөвлөх.

Г.Ганболд: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхдээ энэ бол Засгийн газраас ер нь хариулах ёстой. Бид нар хориг тавихын өмнө асуудлыг судалсан. Таны хэлээд байгаа тухайн үед 46, 47 дугаар тогтоол тусгай хамгаалалтад газар нутаг авчхаад хилийн заагийг нь одоогоор тогтоогоогүй байгаа гэж яриад байгаа бол бас үнэнд нийцэхгүй. 47 дугаар тогтоолоор Ноён уулын дархан цаазат газрыг тусгай хамгаалалтад авсан дархан цаазат газар хилийн заагийг нь бүгдийг нь ингээд тогтоочихсон байгаа. 2020 оны Төрийн мэдээлэл сэтгүүл дээр гаргаснаар энэ хууль, тогтоол хүчин төгөлдөр болдог.

Тэгээд энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн мэдээлэл сэтгүүлийг та үзэх юм бол 1438 дахь хуудсанд энэ 47 дугаар тогтоолоор гарсан Ноён уулын хилийн заагийг бүрэн тогтоочихсон байгаа. 46 дугаар тогтоолоор таны хэлээд байгаа Гутайн даваа болон 6 хавсралтаар ингээд хилийн заагуудыг нь тогтоочихсон бүгдийг нь тогтоочихсон юм байна лээ. Харин зарим нэг цөөн маргаантай газрууд дээр хилийн зааг, дэглэмийг нь тогтоогоогүй байгаа асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бол Засгийн газар тэр яг тогтоогоогүй энэ асуудлууд дээр хариулт хэлэх байх. Зүгээр бид нарын яг хөндөж тухайн тогтоол, хэлэлцүүлгийн явцад яригдаж байсан тэр ашигт малтмалын лицензтэй холбоотой газруудын координат бол энэ дээр ямар ч маргаангүй бүгдээрээ орчихсон юм байна лээ гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Нэмээд Батын Батбаатар сайд хариулах уу?

Б.Батбаатар: Ганхүлэг гишүүний хэлээд байгаа ер нь бол үнэний ор байгаа. Тусгай хамгаалалттай газар нутгийг авахдаа хилийн цэсийг нь буюу том талбайгаар нь бол Их Хурлаас тогтоочхож байгаа. Доторх бүсүүдийг нь, бүсийн хязгаарлалт, бүсийн заагуудыг нь бол тогтоож чадаагүй байж байгаа. Засгийн газарт 8 удаа энэ доторх бүсүүдийн хязгаарыг, хил хязгааруудын дэглэмүүдийг нь зааж оруулъя гэдэг энэ саналыг байгаль орчны салбараас оруулж байгаа. Хэлэлцээгүй Засгийн газрын хэлэлцэх асуудлаас хасчихдаг. Маргааш 3 дахь өдөр энэ асуудлыг хэлэлцэх байсан. Би үгүй болов уу гэж бодож байна. Өчигдөр Бямбацогт сайд бол хэлэлцүүлэхгүй ээ гэдэг зүйлийг хэлж эхэлсэн. Ийм байдалтайгаар тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль нутаг руугаа, газар шороо руугаа.../минут дуусав./

Х.Булгантуяа: Батбаатар сайд нэмж хариулъя.

Б.Батбаатар: Ийм байдалтай л явж байгаа. Засгийн газар дээр энэ асуудлууд шийдэгдэхгүй олон жил явсан. 2020 оноос хойших 5 жилийн хугацаанд тусгай хамгаалалттай газар нутаг 1-ийг ч нэмж аваагүй. Нөгөө 30 он болоход 30 хувь дээрээ очно гэдэг энэ тоо, энэ өнгөрсөн хугацаагаар тоологдож үзэх юм бол бид нар тэр олон улсын өмнө нэгдэж орсон санаачилгатай Монгол Улсын Засгийн газар эзэн болж чадахгүй байна гэдэг ийм л нөхцөл байдал руу орно. Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль бас яамны зүгээс өргөн баригдаж засгаар хэлэлцэгдэнэ. Тэгэхлээр энэ хооронд тодорхой хэмжээгээр лиценз, газрууд аваад маш их хэмжээний нөхөн олговор авахаар нэг ёсондоо татвар төлөгчдөөс хулгай хийхээр зэхэж байгаа энэ ажил бол явсаар байгаа, үргэлжилсээр байгаа гэж ойлгох ёстой. Засгийн газар энэ дээр хурдан, шуурхай ажиллах ёстой байгаа.

Х.Булгантуяа: Ганхүлэг гишүүн нэмж тодруулна.

М.Ганхүлэг: Их Хурлаар баталсан энэ 3 тогтоолын нийт талбай нь болохоор 1.8 сая байгаа. Засгийн газраар хэлэлцэгдэж байгаа мэдээллийг би бас авч үзсэн 1.5 саяар буюу 324 мянган га газрын асуудал хоорондоо зөвшилцөх ийм байдлаар бас явж байгаа. Тэгэхээр ажлын хэсэг болон Их Хурлын зүгээс бол яг энэ анх баталсан энэ байдлаас нь бууруулахгүй байх энэ зарчмыг бас баримталж шаардлагуудаа бас хүргүүлнэ. Энэ дээр бас салбарын сайдын хувьд та бас анхаарлаа хандуулж ажиллах нь зөв гэж бодож байгаа юм. Ерөнхийлөгчийн Тамгын газраас хариулах уу, хаанаас хариулах вэ? Яг Алт-3 хөтөлбөрийн энэ

Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцээгүй тохиолдолд ямар ямар үндсэндээ энэ тусгай хамгаалалттай газрын энэ бүсүүд дээр асуудал үүсэх байсан бэ гэдэг тэр Ноён уул, Гутайн даваа гээд нэрлээд байгаа энэ заагуудыг бас өнөөдөр нэг тодорхой бас олон нийтэд мэдээлчихсэн нь зөв байх. Тэгээд энийг нарийвчлаад би бас дахиад асууя.

Х.Булгантуяа: Энэ их чухал асуулт асууж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс хариулах уу? Хэрвээ энэ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахгүй бол тусгай хамгаалалттай ямар ямар газруудад эрсдэл үүсэх вэ гэдэг ийм асуултыг Ганхүлэг гишүүнээс асууж байна. Тусгай хамгаалалттай газарт ямар ямар газруудад алт олборлолт хийхээр оруулж ирсэн байгаа юм бэ гэсэн асуулт Ганхүлэг гишүүн тавилаа.

Г.Ганболд: Энэ. Шууд 47 дугаар тогтоолд өөрчлөлт оруул гэхээр 47 чинь ерөөсөө ганцаараа Ноён уул л байгаа шүү дээ. Ноён уулын дархан цаазат газар байгаа. Тэгэхээр 47 дугаар тогтоолыг өөрчлөлт оруулна гэх юм бол ерөөсөө Ноён уулын дархан цаазат газраас тэр Гацууртын уурхай ашиглана л гэж ойлгож байгаа. 46 дээрээс нь би хэлэлцүүлгийг та бүхэн Их Хурлын гишүүд бүгдээрээ санаж байгаа байх. Яг тухайн үед нь тогтоолын хэлэлцүүлэг явж байх үед тухайн салбарын сайд болон мэргэжлийн хүмүүс хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ерөөсөө тов тодорхой 3 ордын тухай л ярьж байсан. Гутайн даваа, Гацуурт, Эрээн, Баавгайт гээд. Тийм учраас энэ 3 бол ерөөсөө 47 Ноён уул, 46 дээр нь шууд тэр 2 Гутайн даваа Эрээн.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Бид нарын хэлэлцэж байгаа энэ хоригийг хүлээж авах хэсэгтэй холбоотой ерөнхий агуулгын хувьд бол энэ агуулгыг нь харахаараа энэ бол эдийн засгийн хориг л харагдаад байгаа юм. Энэ нэг Засгийн газар дүлгэнээд түрүүн хүний гараар могой бариулна гээд Ариунзаяа гишүүн бас хэлж байх шиг байна лээ. Их Хурлаар нэг юм хийлгэх гэж үзээд ингээд 2 дахь могой барьж байгаа хүн нь Монгол Улсын Ерөнхийлөгч болж байна л даа. Одоо 1 унц алтны үнэ 2025 оны 9 дүгээр сарын 22-ны байдлаар 3721ам.доллар. Энэ хүн төрөлхтөн энэ алт гэдэг металлыг олборлож эхэлснээс хойш хамгийн дээд цэгтээ үнэ нь хүрч байгаа. Энэ прогнозыг хараад Засгийн газар нь алтны олборлолтоо нэмье. Ингээд инфляцдаа идэгдэж байгаа энэ эдийн засгаа өөд нь татъя, валютын урсгалаа нэмэгдүүлье гэдэг ийм бодлого бариад явсан.

Тэгээд энэ нь зогсож байна л гэж агуулгын хувьд ингэж харагдаж байгаа юм. 100 тонн алттай үндсэндээ нэг ийм манайд байгаа алтны ордуудын хэмжээг нь харж байгаад 100 тонн алттай хэдэн ордуудаа л ашиглая гэсэн юм байна лээ. Өмнөх Засгийн газрын өгч байгаа мэдээллийг би ярьж байгаа шүү. Өмнөх Засгийн газрын үед Уул уурхайн сайдын өгч байсан мэдээллийг ярьж байгаа. Энэ хоригийг тавьж байгаагаа тайлбарлахдаа Ноён уул гээд ингээд ноён уулаа ухах гээд байна гэхээр хэн ч сонссон их эвгүй сонсогдоод байгаа юм. Нээрээ тийм юм болов уу, түүхэн дурсгалт газар, төрийн тахилгатай, дархан цаазтай уулаа ухах гээд байна гээд. Яг тэгж харагдаад байгаа.

Гэтэл яг энэ 100 тонны нөөцтэй гол тэр ордууд нь Гацуурт, Эрээн, Баавгайт гээд энэ ордууд нь яг нөгөө Ноён уулаасаа 10км-ийн-ийн хол гэдгийг хэн ч ярихгүй

байгаа. Хол байдаг. Зүгээр энэ 10км-ийн зайтай байхад нь 2020 онд тухайн үед бас дархан цаазат газрынхаа тэр Ноён уулын хүрээ хязгаарыг нь нэмчихсэн, өргөтгөчихсөн дархан цаазат бүсээ. Бас л улс төржсөн манай төрийн чинь дандаа бизнесийнх нь төрийн эрх барьж байдаг учраас өөрсдийн эрх ашгаараа би биш бол өөр хэн ч биш гээд л өргөтгөчихсөн.

Ингээд Монголын томоохон алтны нөөцтэй ордууд нь тусгай хамгаалалтад орчихсон ийм л юм байгаа юм. 100 тонн алт гэдэг чинь бол одоогоор 3.1 сая уначихсан алт. Энийг нь өнөөдрийн ханшаар бодох юм бол 11.5 тэрбум ам.доллар. 41 их наяд төгрөг. Тэгээд бид нар мөнгөгүй гээд л ингээд яриад сууж байгаа. Тэгээд мөнгөө олъё гэхээр болохгүй ээ энэ бол тусгай хамгаалалттай газар гээд байдаг. Хүмүүстээ ойлгуулахдаа Ноён уулыг чинь ухах гээд байна гээд байдаг. Яг нөгөө орд нь 10км-ийн цаана байгаад байдаг. Яг энэ ордонд бас энэ улс төрийн биш ээ уул уурхайн популизм яг ид халуун яригдаж байна л даа. 1 минутаа нэмээд авчихъя.

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн нэмэлт 1 минут.

Ч.Лодойсамбуу: Нэг юмаа тодорхой болгомоор байна төр нь. Уул уурхайгаа ашиглах юм уу, ашиглахгүй юм уу? Дархан цаазтай юм бол бүгдийг нь дархан цаазтай байлгамаар байна. Жишээлбэл манай Богд уул чинь дархан цаазтай мөн л ялгаагүй төрийн тахилгатай. Яг энгэрээс нь нэг толгойг нь талх зүсэж байгаа юм шиг зүсэж аваад байшин бариад Зайсан хийл гэж бичээд барьчихсан хүмүүс нь энэ танхимд сууж л байгаа шүү дээ. Ялгаагүй дархан цаазтай, төрийн хамгаалалтад байдаг, тусгай хамгаалалтад байдаг. Одоо нөгөө талд нь үнэт металаа олборлоё, улс орныхоо эдийн засгийг бодъё ингээд явъя гэхээр Ноён уулаас нь 10км цаана байгаа тэр ордыг Ноён уулдаа хамааруулж яриад ингээд зогсоогоод ийм байдлаар бид нар цаашаа ер нь хөгжил ярих боломжгүй юм байна даа. Шинэ парламент байгаад ч нэмэр байхгүй, шинэ гишүүд байгаад ч нэмэр байхгүй.

Х.Булгантуяа: Энэ дээр 4 номерын микрофон хариулах уу?

А.Үйлстөгөлдөр: Алтны өмнө нь олгосон байгаа лицензүүд бол багадаагүй. Нийтдээ 230 тонны нөөц байгаа гэж үзэж байгаа. Эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байгаа алтны үндсэн ордууд байгаа. Тэгэхээр Ерөнхийлөгчийн хориг бол ерөөсөө энэ Алт-3 хөтөлбөрийг дэмжихгүй байгаа асуудал бол биш. Хэсэгчилсэн хориг тавьж байгаа дээрээс нь бусад бүх нөхцөлүүдийг дэмжиж байгаа. Тэгэхээр тусгай хамгаалалттай газар руугаа орохгүйгээр бусад үндсэн ордуудын эргэлтэд оруулах бүрэн боломж байгаа гэж харж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтуудаа татах боломж, нөхцөл байдал үүсэж байна. Компаниудаа, аж ахуйн нэгжүүдийнхээ дарамтыг багасгах боломж бололцоо байна. 80 гаруй алтны үндсэн орд байна шүү дээ. Хайгуулын лиценз гэх юм бол бүүр 500 гарсан.

Тэгэхээр 14-хөн орд дотроо л олборлолт хийсэн түүхтэй. Тэгэхэд бид нар дахиад 60 хэд байна. Энэ бүх боломжоо ашиглах боломж байгаа шүү л гээд байгаа юм. Бас бусад уул уурхайтай холбоотой алтны өөр олборлолт эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл байдлуудыг бүгдийг нь дэмжиж байгаа. Боломж байхад ухаад яах юм бэ. Боломжгүй болсон тохиолдолд дараа нь ярья л гэдэг асуудал гэж ойлгож болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Дөнгөж сая Батбаатар сайд 84 үндсэн орд одоогоор ашиглагдаагүй байгаа эдгээр нөөц нь 200 тонн гэж бас мэдээлэл өгч байна. Тэгэхээр ер нь бол бид нар эхлээд энэ эдийн 84 орд 200 тонн алтаа эдийн засгийн эргэлтэд эхлээд оруулах нь зөв. Бид нар чинь алт, зэс, нүүрс гээд л 3 бүтээгдэхүүн зарж амьдарч байгаа шүү дээ. Тэгээд гурвуулаа үнэ өсгөчихсөн бол манай эдийн засагт сайн. Гэхдээ нэг зүйл дээр бас анхаарах хэрэгтэй байгаа юм. Жишээ нь 2020 онд КОВИД-ын үед хил хаалттай үед 23 тонн алт Монголбанканд тушаагдаж байсан. 2021 онд 21.7 тонн алт тушаагдаж байсан.

Өнөөдөр 8 тонн ч хүрэхгүй байгаа. Түүхэн дээд хэмжээндээ хүрчихсэн 1970 оноос хойш алт түүхэн дээд хэмжээндээ энд хүрчихсэн үед Монголбанканд олборлосон алт нь тушаагдахгүй байна гэдэг энэ бол хяналт шалгалт сул байгаа буюу хилээр нууцаар гарч байна гэсэн үг. Тийм учраас Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ тэр хилээр нууцаар гарч байгаа энэ алт дээр онцгой хяналт шалгалтаа анхаарахгүй бол 2026 оны улсын төсөв дээр суусан 20 тонн алтыг ирэх жил олборлож чадахгүй. Ийм нөхцөл байдал үүснэ.

Цаашлаад дархан цаазтай, төрийн тахилгатай, тусгай хамгаалалттай ийм газар нутгууд дээр алт олборлоод үйл ажиллагаа явуулаад ингээд нэг үүд хаалгыг нээчих юм бол жишээ нь Гутайн даваа, Ноён уул зэрэг дээр нэг үүд хаалга нээчих юм бол бид нар дараа нь Бурхан халдуныг, Отгонтэнгэрийг, Сутай хайрхныг ухах ийм эрх зүйн гарцыг нээж өгч байгаа шүү. Ийм боломжийг нээж өгч байна гэсэн үг.

Тэгэхээр үүн дээр бид нар бол маш сайн анхаарах хэрэгтэй. Манай Үндсэн хууль дээр чинь төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнана өвлөнө гээд өгүүлбэр байгаа шүү дээ. Тэгээд Ноён уул чинь, Бурхан Халдун чинь, Отгонтэнгэр чинь өв соёл мөн үү мөн, түүх соёл мөн үү мөн. Тэгэхээр энэ зүйл дээр бас бид нар анхаарах хэрэгтэй. Тийм учраас Ерөнхийлөгчийн хоригийг, хэсэгчлэн тавьсан хоригийг дэмжиж байгаа. Ер нь цаашдаа бид нар ийм гарц нээж өгч болохгүй. Одоо байгаа ашиглаагүй тэр 200 тонн бүхий нөөц нь тогтоогдсон 84 ордоо эхлээд ашиглалтад оруулъя.

Х.Булгантуяа: Шижир гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Үдшийн мэнд ээ. Манайх бас нэг юу яамаар байгаа юм энэ хуулиа биелүүлж л ажилламаар байгаа юм л даа. Хууль дээдэлж. Тэгээд сая хараад байхад тэр завсарлага дээр бол Тамгын газар Үндсэн хуулийн цэц ч юм шиг, Улсын дээд шүүх ч юм шиг хууль тайлбарлах ийм эрх байхгүй шүү. Хуулийн ийм ийм заалт байна гэдгээ л уншиж танилцуулах ёстой. Тэрийг хууль зөрчсөн байна, буруу, зөрүү байна гэдгийг зохих газрууд нь л гаргах ёстой шүү дээ. Тийм энийгээ бид нар энэ танхимаасаа эхлээд л биелүүлж ингэж ажиллаж баймаар байна. Тийм алт Ерөнхийлөгчийн хориг бол үндсэндээ бол зөв юм. Бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч маань тэр ард түмнийхээ л төлөө л ажиллаад байна шүү дээ. Энэ бэлчээр энэ тэр бол байхгүй болж байгаа л даа, хүнд байгаа.

Тухайлбал, саяхан над руу утсаар ярьж байна орон нутгаас, аймгаас, Бөмбөгөр сумаас Баянхонгорын. Зүгээр нөхөн сэргээлт нэрээр эрүүл газрыг аваад тэр аймгийн дарга нь гарын үсэг зураад өгчихдөг нөгөө сумынх нь Засаг дарга байсан хуучин МАН-ын дарга нь тэр Байдрагийн голын нэг ерөөсөө хүрээгүй газрыг л нөхөн сэргээнэ гээд алт олборлож байх жишээтэй. Ийм замбараагүй нөхцөл байдал бий болчихоод байгаа юм. Нөгөө талаасаа бол техник технологи өндөр хөгжсөн, өнөөдөр түүхэндээ байгаагүй үнэтэй болж байна алт. Цаашдаа ч өсөж байна.

Гэтэл манай валютын нөөцийг бүрдүүлдэг алтаар л байх ёстой л доо. Яг ийм эргэлзээтэй үед. Гэтэл өнөөдөр 10 тонн алттай байна уу, үгүй юү жилдээ олборлож байгаа юм. Бид нар болохоор тэр хилийн дээс рүү ухах ёсгүй. Тэндээс хол байх ёстой гэх мэтчилний ийм ийм заалтууд оруулаад байгаа. Харин тэгэх тусмаа тэр рүүгээ олборлох ёстой, тэрийгээ эзэмших ёстой бусад улс орнууд тийм л байдаг юм байна лээ шүү дээ. Дархан хил гэхээрээ л наад талд нь байгаа юмаа бид нар ашиглахгүй хэрэглэхгүй, тэр дархан гэдэг утгаар нь ойлгоод байгаагаас биш хил л дархан байх ёстойгоос биш тэнд байгаа ашигт малтмалаа аль болохоор бид нар олборлож хэрэглэх ийм ёстой байдаг бусад улс орон шиг. Энэ талаас нь хандмаар байгаа юм.

Тэгээд манай энэ Засгийн газар, Улсын Их Хурал энэ ажлын хэсгүүд нь аягүй тааруу ажилладаг юм байна лээ. Энэ юмаа ялгаж салгаад юуг нь яаж олборлох юм, ТЭЗҮ-ийг нь хэр эрт хийсэн юм, хэр бодитой хийсэн юм гэх мэтчилнийг нь хянаад, шалгаад ингээд энэ юмаа ялгаж салгаж ойлгуулах ийм юм нь аягүй дутагдалтай юм билээ. Тэр чинь 4000 хүрчихвэл 1000-аар нь эргэж нөхөн сэргээгээд ингээд ажиллах ёстой байтал энэ юмаа бид нар.../минут дуусав./

Х.Булгантуяа: Ганбат гишүүн үг хэллээ тээ? Ганбат гишүүн ээ Улсын Их Хурлын тухай хуулийн 47.1-ийн дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга бол, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга бол Улсын Их Хурлын дэгийн зөвлөх байгаа. Мэдээж Улсын Их Хурлын дэгтэй холбоотой асуудлуудыг Улсын Их Хурлын Тамгын газар ялангуяа дэгийн зөвлөхтэй бол энэ бүгдийг зөвшилцөж хийж байгаа. Улс төрчид бид нарын хувьд энэ Улсын Их Хурлын ялангуяа чуулганыхаа хуралдааныг аль болохоор улс төржүүлэхгүй, дээрээс нь дэгээ барих, мэдээж Үндсэн хуулийн аливаа зөрчилгүй явуулах дээр бид нар бүгдээрээ анхаарах ёстой. Улсын Их Хурлын Ерөнхийлөгчийн хоригийн асуудлыг бас хэлэлцэж байна. Ганбат гишүүн үүнтэй холбоотойгоор бас санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр.

Д.Батбаяр: Ерөнхийлөгчийн тавьсан хэсэгчилж тавьсан хоригийг зарчмын хувьд нь дэмжиж байгаа. Ер нь бол бид нар энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бол бэлэн биш байгаа нь гэдэг нь өнөөдөр харагдаж байна. Мэдээж эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч байгаа, валютын эх үүсвэр дундарч байгаатай холбоотойгоор Алт-3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагагүй байгааг бол ойлгож байгаа.

Гэхдээ энэнээсээ өмнө бид нар Алт-1 хөтөлбөр, Алт-2 хөтөлбөрийн үр дүнг энэ хөтөлбөрүүдийн хүрээнд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа байгаль орчиндоо хэрхэн хандсан байдал, нөхөн сэргээлтийг хэрхэн хийсэн бэ гэдэг дээр

нь үнэлэлт, дүгнэлт өгөхөөс нааш дараагийн хөтөлбөрийг эхлүүлэх нь учир дутагдалтай юм байна гэж би харж байна. Тэгээд энэ ашигт малтмалыг олборлохтой холбоотой энэ үйл ажиллагааг зохицуулдаг, хянаж зохицуулдаг төрийн байгууллагууд яам, тамгын газруудын өгч байгаа мэдээллүүдийг харахаар бүгдээрээ маш их ажил хийчихсэн харагдаад байдаг. Бүгд өөр өөрийнхөө хаяагаа манасан байдалд. Гэтэл бодит байдал дээр ийм биш байна. Бодит байдал бол гамшгийн байдалтай байгаад байна.

Зөвхөн нэг жишээ гэхэд манай Төв аймгийн төвийн бүсийн Сэлэнгэ аймаг Ерөө сумын Бугант тосгон Бугант баг дээр асуудал маш хүндэрсэн байгаа. Нийгэм тэр аяар өнөөдөр ярьж байна. Нутгийн иргэд бүгдээрээ лайв хийж олны анхаарлыг хандуулахыг зорьж байна. Тэнд гол байна уу байна, мод байна уу байна, ус байна уу байна нөгөө нэг урт нэртэй хууль маань харин хэрэгжиж байна уу гэвэл хэрэгжихгүй байна. Яг энэ нөхцөл байдал дээр бас жишээ хэлэхэд энэ Сэлэнгэ аймгийн удирдлагууд нь өөрсдөө бас байхгүй болчихсон. Сэлэнгэ аймгийн удирдлагууд тэнд лиценз олгохтой холбоотой зөвшөөрөл өгдөг, газрынх нь зөвшөөрлийг өгдөг, хамтын ажиллагааных нь гэрээг нь хийдэг.

Гэтэл юу хийгээд байгаа нь энэ байгаль орчныг сэргийлэх энэ хууль бус алт олборлолтыг зогсоох тал дээр яг ямар ажил хийж байгаа нь тодорхойгүй байгаад байна өнөөдөр. Тэгэхээр үнэхээр ингээд хүчин мөхөстөөд байгаа юм бол энэ хууль бус олборлолттой тэмцэж чадахгүй байгаа юм бол, нинжа нартай тэмцэж чадахгүй байгаа юм бол тэгвэл дараагийнхаа ажлыг эхлүүлэх ямар шаардлага байгаад байгаа юм? Ерөөсөө цөмөөрөө ингээд нэг шинээр газар эхлэхээсээ өмнө, шинээр газар ухаж эхлэхээсээ өмнө энэ байгаль орчныхоо эсрэг хийгдэж байгаа энэ гэмт хэрэгтэй тэмцдэг болчихъё. Тэрний дараа шинэ хөтөлбөр эхлүүлэе. Шинэ газар ухаж эхлэхээсээ өмнө нөхөн сэргээлтээ хийдэг болчихъё. Хууль ёсны зөвшөөрөлтэй алт олборлож байгаа компаниудад нөхөн сэргээлтээ хийх тал дээр нь хяналт тавьдаг болсныхоо дараа шинэ хөтөлбөр эхлүүлэе.../минут дуусав./

Х.Булгантуяа: Батбаяр гишүүн нэмж 1 минут өгье.

Д.Батбаяр: Тэгэхээр яг энэ Сэлэнгэ аймгийн Ерөө, ер нь Сэлэнгэ аймгийн бүх газар нутгуудад энэ өрнөөд байгаа энэ хууль бусаар алт олборлож байгаа энэ байгаль орчны эсрэг үйлдэгдэж байгаа энэ гэмт хэргийг таслан зогсоохоосоо наана, зогсоохоосоо өмнө энэ дараагийн энэ Алт-3 хөтөлбөрийг эхлүүлэхээ больё. Эхлээд цөмөөрөө хуулиа хэрэгжүүлдэг больё, эхлээд цөмөөрөө байгаль орчноо хамгаалдаг болчихъё тэрний дараа дараагийнхаа хөтөлбөрийг эхлүүлэе ээ гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ утгаараа энэ Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг дэмжиж байгаа. Мөн Улсын Их Хурлын гишүүддээ бас энэ хоригийг хүлээж аваасай гэж уриалмаар байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батбаяр гишүүн үг хэллээ. Үг, асуулт хамтдаа явж байгаа учраас нэмэлт 1 минутаар бас цаг аваад хэлээд явж байгаа. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга. Гишүүд ээ үүнтэй холбоотой санал хураалтыг өнөөдөр явуулахад Эдийн засгийн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцүүлэг одоо яг бас явж байна. Дээрээс нь нэмээд Төсвийн байнгын хорооноос бас төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой бас хэлэлцүүлэг бас яваад чуулганы хуралдаан дээр, чуулганы хуралдаан дээр санал хураалтыг тэгэхээр нэгдсэн журмаар маргааш явуулах нь зүйтэй юм байна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-т хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэсний дагуу санал хураалтыг маргааш 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай байгаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд эхэлсэн даруйд явуулах нь зүйтэй юм байна гэж үзэж байна. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. 2025 оны 7 сарын 9-ний энэ Алт-3-ын аянтай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын 5 дугаар зүйл дээр бол Ерөнхийлөгчийн хориг тавигдлаа гэж бол ойлгосон. Ингээд яг энэ хоригийнхоо өгүүлбэрийг нь өгүүлбэрээр нь уншихаар гадаад валютын богино хугацаанд нөөцийг нэмэгдүүлж, үр өгөөжийг өгөх Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудыг судлаад тэгээд улсын тусгай хамгаалалттай газрууд тэр 46, 47 гэсэн тогтоолуудыг дурдаж байгаа юм. Тэгээд эргээд Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх вэ гэсэн агуулгатай ийм заалт. Тэгтэл манай Ерөнхийлөгчийн Тамгын газрынхан чинь их сайн л ажилладаг л даа.

Гэхдээ арай л нэг үе шат түрэгдээд ороод ирчихсэн юм шиг. Их Хурал дээр яг төсвийн тодотгол дагаж орж ирсэн энэ тогтоолын үеэр бол тогтоол Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр яг ямар төслүүд байгаа нь бол мэдэгдээгүй шүү дээ. Тэгээд тэр мэдээллээ яг хаанаас аваад яг аль нь юм бэ гээд. Тэгээд тэгэнгүүт 46, 47 тэр тогтоолуудыг уншаад тэр орд нь байх гээд л таамаглаад л бүх юм нь таамаг дээр яваад л. Тэгээд явж явж байснаа зүгээр Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруул гэсэн заалт дээр хориг тавиад тэгээд арай л түргэдчихсэн юм шиг. Ядаж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам энэ судалгаагаа хийгээд эргээд Их Хурал дээр орж ирэхэд нь хил заагаа ярилцаад, ярилцах ёстой байсан юм шиг санагдаад байх юм. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Батбаатар сайд сууж байна. Улсын тусгай хамгаалалттай, тусгай хэрэгцээтэй газар нутагтай холбоотой мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд заавал өгөхийг хүсэж байна. Газрын тухай хууль дээр бол тусгай хэрэгцээний газар нутгийн ангиллыг бол тодорхой 16 дугаар зүйл дээр бичсэн байдаг. Улсын тусгай хамгаалалттай газар нийт нутаг дэвсгэрийн 21 хувь гээд таны хэлж байгаа зөв. Цааш нь унших юм бол орон нутгийн тусгай хамгаалалттай газар гээд тодорхой хувь байдаг. Улсын хилийн газар батлан хамгаалах зориулалттай газар гээд отрын бэлчээр, орон нутгийн тусгай хэрэгцээний газар гээд бүх газруудаа нэмбэл Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 74 хувь нь ямар нэгэн ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжгүй газар нутаг байдаг. Зөвхөн 26 хувь дээр нь үйл ажиллагаа явуулах боломжтойгоос одоо 1.2 хувь байна уу тэрэнд нь л “А” тусгай зөвшөөрөл байгаад тэрнийх нь 0.25 хувьд нь л ашиглалт явж байна. Ийм яг бодит статистик нь ийм байдаг. Тэгэхээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 30 хувьд нэмж хүргэнэ ээ гэхийн оронд энэ бусад энэ ангиллуудыгаа эргэж харах цаг болсон юм шүү. 30 хувь бол дорхноо хүрнэ гэж боддог. Тэгээд энэ дээр бас таны бодлыг сонсьё.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон ажлын хэсэг.

А.Үйлстөгөлдөр: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ түргэдсэн асуудал бол болоогүй. Энэ тогтоолын тэр 5 дугаар заалт дээр бол маш тодорхой биччихсэн байгаа байхгүй юу. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах хилийн заагт өөрчлөлт оруулах тухай 20 оны 46 дугаар тогтоол, 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж яаралтай өргөн мэдүүл гэж байгаа юм.

Тэгээд энд өөрчлөлт оруулах гэдэг үгэн дээр шууд санаа агуулж байна л гэж үзээд байгаа юм. Нэмэлт, өөрчлөлт гэж үг байсан бол бас өөрөөр ойлгож болохоор. Өөрчлөлт орууллаа гэхээр 46 бол мэдээж тусгай хамгаалалттай газар, 47 тэгэхээр Ноён уул, Гутаан даваа, бас бус газрууд гээд үзэсгэлэнт байгалийн газруудыг өөрчилж оруулж ирээд хавсралтад гээд өөрчлөх үүрэг даалгавар өгчхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг шууд санаа агуулж байна л гэж үзсэн байгаа бид нар. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд. Батбаатар сайд, Батын Батбаатар сайд.

Б.Батбаатар: Би Ноён уул дээр очиж үзсэн шүү дээ. Ноён уулын дотор нь л тэр алтны уурхай байж байна лээ. Тэнд 85 тонн нөөц байгаа гэсэн, Гутаан даваан дээр 15 тонн нөөц байгаа гэсэн ийм мэдээллийг өгч байгаа. Тэр тусгай хамгаалалттай газар нутагт тэр хил дотор нь байгаа, хамгаалалт дотор байгаа газар нь кемп нь байж байдаг. Байгаль хамгаалагчид орж чаддаггүй. Газар дээрээ нөхцөл байдал нь тийм байсан. Хамгаалалттай газар, тусгай хамгаалалттай газар нутаг дотор тэр алтны уурхайнууд оршиж байгаа. Тэрийг дотор нь цонхолж тусгай хамгаалалтаас гаргах тухай л тогтоол шүү дээ хаврын тогтоол чинь. Тэр 74 хувь байгаа тусгай хэрэгцээний газар эд нар гээд энэ нь янз бүрийн шалтгаанаар олгогддог юу тусгай хэрэгцээний газар нөөц газар юу байдаг юм орон нутгийн авдаг. Энэ газар зохион байгуулалтын алба ингээд өөр тийшээ шилжсэн энэ газар зохион бай.../минут дуусав./

Х.Булгантуяа: Батын Батбаатар сайдын микрофоныг нэмж өгье. Гүйцэд хариулъя.

Б.Батбаатар: Тэр янз бүрийн хэрэгцээ болоод бусад зориулалтаар авсан газар нутагтайгаа нийлээд 74 хувь болчихсон гэдэг бол үнэн. Тэд нар чинь бол тусгай хамгаалалтад буюу байгалийн эх төрхөөр нь авч үлдэхээр хамгаалж авч үлдээд байгаа биш зам харгуй барих, хот барилга, байшин юу байдаг юм батлан хамгаалах эд нар гээд зориулалтуудаар аваад байгаа. Тэд нар дээрээ өөрчлөлтүүд оруулаад тусгай хамгаалалттай буюу байгалийн унаган төрхөөр нь, эх төрхөөр нь авч үлдэхийг 30 хувь болгоод нөгөөдүүл дээр нь бүтээн байгуулалт, уул уурхай, газар тариалан бусад юм явдаг байх тэр боломжийг бүрдүүлэх нь бол зүйтэй санал нийлж байгаа юм.

Х.Булгантуяа: Уянга гишүүн нэмж хариулъя.

Б.Уянга: Тийм. Юун дээр Их Хурлын, Ерөнхийлөгчийн Тамгын газрынхантай харин яг нэг өгүүлбэрийг уншаад л байгаа юм л даа. Яг энэ 5 дугаар заалтынх нь хүрээнд ямар ямар төслүүд орж ирэх юм бол гээд тэрийг нь хүлээж байтал орж ирэх боломжгүй болох үйл явдал болж байгаад л жаахан сонин санагдаад байгаа

юм. Тэгээд тэр нэг судалгааг нь холбогдох яамаар нь хийлгээд орж ирэхэд нь бүгдээрээ бүх зүйлүүдээ сайхан талаас нь ярьсан бол дээр байсан байх магадлалтай л байх. Батбаатар сайдын хариултыг ер нь энэ Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай хэрэгцээний газар нутаг Монгол улсын нутаг дэвсгэрийн 74 хувийг хамраад байгааг эргэж харна гэж байгаад бол талархаж хүлээж авч байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 30 хувь руу хүргэнэ гэсэн олон улсад манай Монгол Улс хэрвээ амлалттай тэрийгээ биелүүлэх шаардлагатай бол орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудыг эргэж үзье, чөлөөтэй 30 хувь руу хүрэх боломжтой гэж үздэг. Тэгээд энэ дээр хамтарч ажиллахад бас бэлэн.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэг асуултыг тодруулж асууя. Түрүүн бас хэд хэдэн гишүүд асуугаад Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга бас хариулж байсан. Ерөнхийлөгчийн тогтоолд хэсэгчлэн хориг тавих тухай 2 дугаар зүйл, заалт дээр Үндсэн хуулийн зарчим тогтоолд нийцүүлэх нь зүйтэй гээд түрүүн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга бас хэлж байсан хориг тавихад тэр чигээрээ төсөв дээр хориг тавигдах гээд байсан учраас бид хэсэгчлэн салгаж ингэж гаргасан гээд үүн дээр ажлын хэсгээс 4 номерын микрофон нэмэлт тайлбар өгье.

Г.Ганболд: Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавихдаа ер нь бол 5 дугаар заалт буюу саяын тэр тусгай хамгаалалтаас гаргах заалт дээр хориг тавьсан. 2 дугаар заалт нь ер нь яг энэ 2 дугаар заалтыг би Төсвийн байнгын хороон дээр Төсвийн байнгын хорооны даргад хэлж байсан л даа. Хугацааны хувьд Ерөнхийлөгч хориг тавих санаа агуулаагүй. Хэрэв хориг тавьсан бол Үндсэн хууль зөрчсөн байна гээд шууд тавина. Энэ дээр зүгээр ер нь гарч байгаа тогтоол, шийдвэрүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг зөрчих шинжийг агуулсан байна шүү гэж ер нь Их Хуралд сануулсан ийм агуулгатай 2 дугаар заалтыг явуулсан юм. Хэрэвзээ хугацаан дээр хориг тавьсан бол тогтоол бүхэлдээ хориг тавигдана гэж бид нар ойлгож байгаа. Тэгэхээр яг энэ 2 дугаар заалтын энэ хугацаан дээр бол Ерөнхийлөгч хориг тавиагүй. Ер нь 5 дугаар заалт дээрээ хориг тавьсан гэж ингэж ойлгож болохоор байгаа юм. Би Байнгын хорооны хурал дээр Байнгын хорооны дарга, хуулийнханд хэлсэн боловч энийг Байнгын хороо ингэж ойлгож байна гэдэг агуулгаар санал хураагаад явсан.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, одоо яг 2 хуралдаан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрсдэлийг нарийвчлан судлах ерөнхий хяналтын сонсгол өглөөнөөс Улсын Их Хурлын Чингис хаан танхимд үргэлжилж байна. Хөдөө орон нутгаас их олон төлөөлөлтэй салбарын төлөөлөл орсон нэлээн урт хэлэлцүүлэг болж байгаа. Хяналтын сонсгол болж байгаа. Мөн Төсвийн байнгын хорооноос улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төслүүдийн хэлэлцүүлгийг бас зохион байгуулж байгаа. Нэгэн зэрэг 2 газар 3 Байнгын хорооны гишүүд бас хэлэлцүүлэгтэй байгаа тул Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахтай холбоотой санал хураалтыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу маргааш нэгдсэн чуулганы хуралдаан эхэлсэн даруйд явуулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Маргааш 10 цагаас чуулганы хуралдаантай байгаа. Тэгэхээр нэгтгэн явуулъя. Ингээд дараагийн асуудалдаа орёе.

15.49 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, илтгэгч Ц.Цолмон, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн Дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Б.Будхүүгийн итгэмжилсэн төлөөлөгч Б.Цэндсүрэн болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт нь нийт 34 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 26 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн тэмдэглэл болон үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл.

Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь эрх зүйн тодорхой байдал болон тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх, шүүхийн хяналт байх зэрэг зарчмыг хангахыг Үндсэн хууль шаардана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж заасан нь шүүгдэгчийн бие махбодын эрх чөлөөг хасах ноцтой хязгаарлалт боловч эдгээр зарчмыг хангахгүй байгаа нь тогтоогдож байна. Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтын дагуу хүнийг нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлах аливаа арга хэмжээний үндэслэл, журмыг хуульд тодорхой заах бөгөөд дур мэдсэн шинжтэй байж болохгүй.

Тухайлбал, хүнийг цагдан хорих үндэслэлийг хэт өргөнөөр, эсвэл дур мэдэн тайлбарлах, хэрэглэхээс сэргийлэх үүднээс хуульд ерөнхий тусгах бус харин нарийвчлан тодорхойлох ёстой. Улсын Их Хурлаас 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчийг цагдан хорих үндэслэлийг дэлгэрүүлэн зохицуулсан байх бөгөөд уг арга хэмжээг зөвхөн хорих ял оногдуулахаар хуульчлагдсан гэмт хэргийн яллагдагчид авахаар заасан нь хүний бие махбодын эрх чөлөөг хамгаалахад дэвшилттэй болжээ.

Энэ хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн тус арга хэмжээг яллагдагчид авах заалтыг халсан боловч шүүгдэгчийг ийм ерөнхий заалтаар цагдан хорихоор болохоор зохицуулсан байна.

Шүүгдэгчийг цагдан хорих үндэслэл нь яллагдагчийг цагдан хорих үндэслэлээс мөн чанарын хувьд ялгаатай байх зүй ёсны хэрэгцээ шаардлага тогтоогдоогүй болно. Гэвч шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг яллагдагчийг цагдан хорих үндэслэлтэй адил нарийвчилж зааж өгөөгүйгээс шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн гэх ерөнхий үндэслэлээр, эсвэл хуулийн бусад ерөнхий заалтыг удирдлага болгон шүүгдэгчид уг арга хэмжээг авч байна.

Улмаар шүүгдэгчийг цагдан хорих эсэхийг тодорхой объектив шалгуургүйгээр үзэмжээрээ шийдвэрлэх бүрэн эрхийг шүүгчид олгосон байх тул тус арга хэмжээг дур мэдэн, эсвэл ялгаварлан гадуурхаж хэрэгжүүлэх эрсдэлтэй байх бөгөөд шүүгдэгч ямар үндэслэлээр цагдан хоригдох талаар урьдчилан таамаглах зан үйлээ нийцүүлэх боломжгүй байна. Хүнийг цагдан хорих шийдвэрийг гагцхүү шүүх гаргах бөгөөд цагдан хориход баримталсан үндэслэлийг шийдвэртэй бичих үүрэгтэй. Үүний үндсэн дээр цагдан хорих тухай шийдвэрийн үндэслэлийг тус шийдвэрт гомдол гаргах болон хууль зүйн туслалцаа авах эрхийн хамт тухайн хүнд нэн даруй мэдэгдэх ёстой.

Гэтэл зарим шүүх шийдвэртэй цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, эсвэл хэвээр үргэлжлүүлэх үндэслэлийг хуулийн заалт болон үйл баримтад тулгуурлан ойлгомжтой бичээгүй тохиолдол гарч улмаар шүүгдэгч цагдан хоригдсон шалтгаан үндэслэлээ даруй мэдэх эрхээ эдэлж чадахгүй байна. Хүнийг цагдан хорих журмыг хуульд тодорхой зааж биелэлтийг нь хангах нь Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтын шаардлага бөгөөд түүнийг дур мэдэн хэрэгжүүлж болохгүй. Тухайлбал, цагдан хорих журам тус арга хэмжээний хугацааг тогтоох зэрэг өргөн агуулга багтана.

2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн дээрх нэмэлт, өөрчлөлт нь яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байсныг 1 сар хүртэл болгон цагдан хорих хугацаа заавал 1 сар бус, харин түүнээс богино байх боломжтойг тодруулж, түүнчлэн хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол гэх хэт ерөнхий үндэслэлээр бус, харин тус хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилаагүй гэж үзвэл гэх илүү объектив тодорхой шалгуураар уг арга хэмжээг 1 сар хүртэл хугацаагаар сунгахаар өөрчилж, мөн хорих ялаар ялын хугацаанаас хамааран цагдан хорих дээд хугацааг бууруулсан зэрэг дэвшилттэй болсон байна.

Харин тус нэмэлт, өөрчлөлтөөр шүүгдэгчийг цагдан хорих журамтай холбоотой зарчмын шинэчлэл хийгдээгүй байна. Тухайлбал, шүүгдэгчийг цагдан хорих хугацааг тусгайлан хуульчлаагүй ч практикт энэ хугацааг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар хязгаарладаг гэж ойлгодог байна. Гэвч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хугацааг удаа дараа сунгах, шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах, дээд шатын шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатын шүүхэд буцаах, анхан шатын шүүхээс хэргийг прокурорт буцаах зэрэг шалтгаанаар уг хугацаа хэтэрч хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол гардаг бөгөөд ийнхүү удаашрах нь яллагдагч, шүүгдэгчийг урт хугацаагаар цагдан хориход нөлөөлж байна. Шүүгдэгчийг цагдан хорих, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх хугацааны дээд хязгаарыг хууль тогтоохоос илүүтэй зарчмын шинжтэй зохицуулалт байх боломжтой ч энэ нь хангалттай хуульчлагдаагүй байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх заалтын шударга шүүхээр шүүлгэх эрх нь зохисгүй, удаашралгүйгээр шүүлгэх болон бусад баталгааг багтаасан өргөн агуулгатай. Энэ баталгаа нь хуулиар тогтоосон хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэхээс гадна үндэслэл бүхий хугацааны дотор аль болох шуурхай хянан шийдвэрлэхийг шаардана. Гэвч зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрх, уг эрхийг хангасан эсэхийг тодорхойлох хүчин зүйлийг хуульд бүрэн тусгаагүйгээс хянан шийдвэрлэх ажиллагаа зохисгүй удааширсан эсэх, энэ явцад яллагдагч, шүүгдэгчийг зайлшгүйгээс урт хугацаагаар цагдан хорьсон эсэх зэрэг асуудлыг тогтоох боломж хумигдаж байна.

Түүнчлэн хуульд заасан үндэслэлээр хүнийг цагдан хорихоор шийдвэрлэснээс хойш тодорхой хугацааны тухайлбал, 1-3 сарын давтамжтайгаар тухайн үндэслэл арилсан эсэхийг тогтмол хянах журмыг хуульд тусгаагүй байна. Иймээс шүүгдэгчийг зайлшгүйгээс илүү урт хугацаагаар цагдан хорих энэ арга хэмжээ шүүхийн хяналтаас гадуур болох, улмаар шүүгдэгч эрүү шүүлт, эсвэл хүнлэг бус хэрцгий, доромж хандлагад өртөх, эсвэл амь нас, эрүүл мэндэд нь аюул учрах эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна. Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилготой, энэ зорилгод хүрэхэд уялдаатай зайлшгүй тэнцвэртэй байх шалгуурыг хангах ёстой. Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчийг цагдан хорьж болохоор зохицуулсан нь тус ажиллагааг хэвийн явуулах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн уялдаатай байна.

Гэвч энэ зохицуулалт нь хэт ерөнхий үндэслэлээр шүүгдэгчийг цагдан хорихыг шүүхэд зөвшөөрч, шүүгдэгчийг ялимгүй үндэслэлээр, эсвэл огт үндэслэлгүйгээр үзэмжээрээ, эсвэл дур мэдэн цагдан хорих зайлшгүй шаардлагатайгаас илүү урт хугацаагаар цагдан хорих эрсдэл үүсгэсэн учраас тэнцвэргүй байна.

Шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг хуульд тодорхой зааж, уг үндэслэл арилсан эсэхийг шүүхээс давтамжтайгаар хянах, зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрхийг хуулиар баталгаажуулснаар дээрх зорилтод адилхан хүрэх боломжтой бөгөөд маргаан бүхий зохицуулалттай харьцуулахад бие махбодын эрх чөлөөнд илүү бага халдахаар байна. Үндсэн эрхийг хязгаарласан аливаа арга хэмжээ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эсэх, дур мэдсэн эсэх, тохирсон эсэхийг шүүхээр үр нөлөөтэй хянах шаардлагатай.

Шүүгдэгчийг түүний хувьд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, эсвэл хэвээр үргэлжлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэхээр зохицуулсан байх боловч уг шийдвэрт гомдол гаргах, давтамжтайгаар шүүхээс хянах журмыг тодорхой хуульчлаагүй байна.

Мөн шүүгдэгчид уг арга хэмжээг авах, эсвэл хэвээр үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ цагдан хорих үндэслэл байгаа, эсвэл арилсан эсэхийг нэг бүрчлэн нягталж, хэлэлцэж шийдвэрлэх шаардлага тухай бүр хангагдахгүй байх бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгч биечлэн оролцох эрхтэй эсэх нь хуулийн зохицуулалтаас тодорхойгүй байх тул шүүхийн хяналтын үр нөлөө алдагдаж байна. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу төрөөс хүний бие махбодын эрх чөлөөг хасахгүй байх негатив үүрэгтэй ч энэ эрх чөлөөг хасах буюу хүнийг баривчлах, хорих тохиолдолд түүний үндэслэл, журмыг хуульд тодорхой заах, дур мэдэн хэрэгжүүлэхгүй байх позитив үүрэг хүлээнэ.

Гэвч дээр дурдсанчлан шүүгдэгчийг цагдан хорихтой холбоотой позитив үүргээ төр бүрэн биелүүлэхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг хэт ерөнхий зааж, эрх зүйн тодорхой байдал, тохирсон байх, шүүхийн хяналт байх зарчимд нийцээгүй хязгаарлалтыг хуульчилснаас дур мэдэн хэрэгжүүлэх эрсдэлийг бий болгосон байна.

Тус хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийг энэ дүгнэлт гарсан өдрөөс эхлэн түдгэлзүүлэх нь шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, эсвэл хэвээр үргэлжлүүлэх хуулийн зохицуулалтад хийдэл үүсгэх эрсдэлтэй байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу тус зохицуулалтыг Үндсэн хуульд нийцүүлэх хугацаа тогтоох үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон учир энэ дүгнэлт нь гарсан цагаасаа хойш үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авна гэжээ. Шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авахаар ийнхүү зохицуулсан нь хүнийг хорих аливаа арга хэмжээ шүүхийн хяналт байх зарчмыг хангахтай холбоотой байх тул Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Тус хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаанд энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаа хугацаанд хамаарахгүй гэж заасан. Уг зохицуулалт нь шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа, яллагдагчийг цагдан хорьсон хугацаанд хамаарахгүй гэдгийг нэг мөр болгох замаар эрх зүйн тодорхой байдлыг хангахад үйлчлэх бөгөөд үндсэн эрхийг хязгаарласан шинжгүй байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхээргүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчилсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Мөн зүйлийн 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авна гэж, 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаанд энэ зүйлийн 1. 2 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч: Г.Баясгалан, Гишүүд: Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Р.Батрагчаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 07

дугаар дүгнэлтийг 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр гэмт хэрэг, түүний үйлдэл, учир шалтгаан, хохирогч болон гэмт хэрэг үйлдэгчийн зан байдал харилцан адилгүй байдаг тул хуулийг хэт нарийвчлан тогтоох нь хууль хэрэглээнд хүндрэл үүсэх эрсдэлтэй тул хууль тогтоогч нь шүүхэд уян хатан байдлаар хэрэглэх боломжийг нээж, шүүгчид өөрсдийн дотоод итгэлээр шийдвэр гаргах нөхцөлийг хангах шаардлагатай гэж үзсэнийг Үндсэн хуулийн цэц илүү тодорхой болгох шаардлагатай гэж дүгнэсэн байна. Цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Байнгын хорооноос холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, уг ажлын хэсэгт шүүгч, прокурор, мөрдөх албанаас, мөн судалгаа шинжилгээний байгууллагуудын төлөөллийг оролцуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл шүүгдэгчийн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг шүүх хуралдаан хойшлогдох бүрд автоматаар сунгаж ирсэн нь хууль тодорхой зохицуулаагүй ч практикт нэг ёсны заншлын хэм хэмжээ болон тогтсон. Ингэснээр өмгөөлөгч оролцохгүй, бүрэлдэхүүн бүрдээгүй гэх мэт шалтгаанаар хүнийг урт хугацаагаар хорих нөхцөл бүрдэж байгаа тул Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авч, ажлын хэсэг байгуулан шүүх, прокурорын төлөөллийг оролцуулан нарийн зохицуулалтыг хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал шүүгдэгч, сэжигтэн яллагдагчийн цагдан хорих асуудал нь зарим тохиолдолд субъектив байдлаар шийдэгдэж, олон улсын байгууллагын шинжээчийн дүгнэлтээр ч энэ нь нотлогдсон байдаг тул Цэцийн дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзэн хүлээн авах нь зүйтэй бөгөөд уг асуудлыг хуульд тодорхой нарийн томъёолон тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр цагдан хорихтой холбоотой зохицуулалтыг үгүйсгээгүй бөгөөд хүний эрх, эрх чөлөөнд халдаж болзошгүй практик дээрх алдаа буруу хэрэглээг засаж, завсар зай үлдээхгүйгээр илүү нарийн тодорхой зохицуулалт хийх шаардлагатайг онцолсон гэж ойлгох нь зүйтэй тул уг дүгнэлтийг хүлээн авч, ажлын хэсэг байгуулж хууль тогтоомжид хүний эрхийн баталгааг хангахуйц өндөр шалгуур, тодорхой шаардлагуудыг тусган нямбайлан боловсруулах шаардлагатай талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авч болно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийн болон өмгөөлөгчид хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэснийг, мөн зүйлийн 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэснийг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс

хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 73.3 хувь буюу олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Х.Булгантуяа: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

4 гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Б.Энхбаяр: Баярлалаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Цэцээс биш Цэцэд Улсын Их Хурлыг төлөөлж оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлдэг. Тэгэхдээ тийм учраас би Цэцэд төлөөлсөн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг гишүүнээс тодруулж асууя. Ер нь Улсын Их Хурал хууль тогтоогч ч тэр, Үндсэн хуулийн цэц ч тэр хамтдаа энэ цагдан хорио буюу хорьж мөрдөх аргаар хүнийг улайлгадаг, өөрөөр нь хэргийг нь нотлуулах гэж чичирдэг энэ тогтсон системийг устгах, нураах талаар сүүлийн олон жил тасралтгүй ажлууд хийж байгаа. Үр дүнгүүд ч бас байгаа. Би үр дүн дээр тодорхой тоо хэлье. 2016 онд Хууль зүйн, дотоод хэргийн дэд сайдаар оччихоод 2017 оны 7 сарын 1-нээс шинэ эрүүгийн процессын хууль үйлчилж эхэлсэн байдаг юм.

Тэгээд 2018 оны сүүлээр буюу тэр хуулийн хэрэгжилтийг авч үзэхэд энэ 2002 оны буюу нөгөө хар хууль гэж яригддаг хорьж мөрддөг арга барилтай хуулийн үед цагдан хоригдсон 5 хүний 1 нь шүүх рүү шилжсэн байдаг. Өөрөөр хэлбэл, шүүх рүү цагдан хоригдсон 5 хүний 4 нь шүүх рүү шилждэггүй буюу гэм буруугүй болж гардаг байсан. Энэ бол аймшигтай тоо. 17 оны 7 сарын 1-нээс үйлчилж эхэлсэн хуулийн үр дүнд цагдан хоригдсон 5 хүний 3 нь шүүх рүү шилждэг болсон гэдэг судалгаа гарсан.

Мөн хохирлоо барагдуулах хөшүүргүүд хийснээр хорьж мөрдөх арга барилаас татгалздаг ийм механизмууд нутагшиж ирсэн. Гэхдээ би бүх юм сайхан болчихсон байгаа гэж ерөөсөө хэлэхгүй байгаа. Энэ чиглэлд тасралтгүй хөдөлмөрүүд, тасралтгүй хууль тогтоогчийн санаачилгууд явж байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ч гэсэн хууль тогтоогчийн зорилго, санаа зорилготой бол адилхан байна. Өөрөөр хэлбэл, тэр цагдан хорьж байгаа үндэслэлээ хууль тогтоогч илүү тодорхой болгочих л гэсэн байна. Тэрнээс биш бол цагдан хорьж байгаа нь бол буруу тухай Цэц дүгнэлт гаргаагүй.

Тэгэхээр Улсын Их Хурал хүлээж авъя гэдэг би ийм байр суурьтай байгаа. Хүлээж авсан тохиолдолд энэ ажлын хэсэг гаргаж, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурор, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоотойгоор ажлын хэсэг гаргаж энд их нухацтай хандах ёстой. Тэгэхгүй бол цагдан хорионы үндэслэлийг их тодорхойгүй байдлаар үлдээх замаар одоо хэрэг хийсэн шалгагдаж байгаа

хүмүүсийг мулталчих вий гэсэн санаа зовнил байна. Тийм учраас энэ цэцийн дүгнэлтийн үр дагавар дээр хүн суллагдчих.../минут дуусав./

Х.Булгантуяа: Энхбаяр гишүүд нэмэлт 1 минут.

Б.Энхбаяр: Хүн гарчих вий гэдэг ийм бас зовнил байгаа учраас хууль гаргаж байгаад хэрвээ хүн мулталсан бол энэ их муухай хэрэг болно л доо. Хуулийн хулгай төгс хэлбэр болно. Яагаад гэхээр иймд асуудлууд бол гарч байсан. Манайх мөнгө угаах терроризмтой тэмцэх чиглэлд терроризмын эсрэг зандалчлах гэдэг зүйл ангиар ял шийтгэгдсэн этгээдүүдийг Өршөөлийн хуульд хамруулснаас болоод олон улсын мөнгө угаах терроризмтой тэмцэх байгууллага манай улсыг саарал жагсаалтад оруулж байсан. Танайх терроризмын эсрэг гэмт хэргийг өршөөдөг улс байна гэж. Тийм учраас нөгөө энэ чиглэлд амьтан хүн хуулийн хулгайгаар гарчих, зугтчих, бултчих ийм зүйл байхгүй биз дээ гэж бас Сайнзориг гишүүнээс асууж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Мэдээж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг бас тодорхой дэвшилтэт заалтууд бол байгаа. Хуучин бол хар Баасан гараг гэдэг ч юм уу ямар нэгэн үндэслэлгүйгээр субъектив байдлаар хүнийг цагдан хорьдог, залхаан цээрлүүлдэг явдал бол хавтгай байсан. Одоо энэ байдал бас хуулийн тодорхой үндэслэлийн дагуу цагдан хорих, энэ таслан сэргийлэх арга хэмжээг авдаг болчихоод байгаа. Хуулийн буюу 14.9 дүгээр зүйл дээр уг нь яг хүнийг бол 4 үндэслэлээр цагдан хорих нөхцөлийг заасан тодорхой байгаа. Тэгээд энэ удаагийн Цэцийн маргаан бол цагдан хорих ялын хэмжээнээс шалтгаалаад ер нь зүгээр дээд тал нь 24 сар хүртэл цагдан хорих боломжтой байгаа. 18 сар хүртэл тэгээд 6 сараар сунгах. Тэгээд энэ асуудал дээр бас тодорхой хэмжээний шүүхийн шатад энэ хугацаа тоологдохгүй байна гэдэг асуудал болон шүүгдэгчийн хувьд бас яг ямар үндэслэлээр цагдан хоригдож байгаа нь тодорхойгүй байна гэж яригдсан Цэц дээр.

Тэгэхээр уг нь бол шүүгдэгч гэдэг маань яллагдагч, шүүхэд шилжсэн яллагдагчийг шүүгдэгч гэж байгаа учраас яг энэ хуульд заасан 14.9 дүгээрт заасан үндэслэлийн дагуу л цагдан хоригдож байгаа гэж би Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг хамгаалсан. Тэгэхээр шүүх бол энэ бол тодорхойгүй байна, яллагдагчийн асуудлыг та нар тодорхой ингэж хуульчилсантай адил шүүгдэгчийг мөн адил яг тодорхой бас үндэслэлүүдийг нь зааж өгөх нь зүйтэй гэдэг энэ агуулгыг бол ерөнхийдөө тодорхой ярьж байгаа. Тэгээд зарим асуудлуудыг бол Үндсэн хууль зөрчөөгүй гэж бол гаргасан. Та бүгдэд харагдсан байгаа.

Тэгээд энэ удаагийн бас Үндсэн хуулийн цэцийн шийдвэр дээр бас нэг зүйл байгаа. Улсын Их Хурал бас тодорхой хэмжээний цаг хугацааны боломжийг бол олгосон гэж ойлгож байгаа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан буюу бид нарын энэ хэлэлцэж байгаа Үндсэн хууль зөрчсөн гэж хүлээж авсан тохиолдолд бас тодорхой хэмжээнд ажиллах энэ цаг хугацааг бол Цэц бол 6 сард өгсөн. Бүүр 6 сард. Бид нар энэ дүгнэлтийг харин өнөөдөр л чуулган маань нээгдээд яг процессын дагуу хэлэлцээд 6 сар, 3 сар гаруй дарчихлаа л даа.

Тэгэхээр энэ бас боломж бол байгаа. Тэгээд 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс бол энэ зөрчсөн гэдэг шийдвэр дээрээ түдгэлзүүлнэ шүү. Тэр болтол та нар бас тодорхой арга хэмжээ ав гэдэг энэ заалтыг хийж байгаа. Тийм учраас Энхбаяр гишүүний хэлж байгаа шиг энэ заалтыг өнөөдөр хүлээж авсан ч гэсэн ямар нэгэн байдлаар цагдан хорионоос хүмүүст суллагдах ч юм уу ийм зүйл бол байхгүй. Энэ заалт 26 оны 1 дүгээр сарын 1-нээс түдгэлзэнэ. Тэр хүртэл бид нар засчихвал энэ асуудал илүү их тодорхой болоод явчих ийм нөхцөл байдалтай байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Энхбаяр гишүүн гэмтэй хүмүүсийг суллагч вий гэж байгаа бол би нөгөө талдаа гэмгүй хүмүүсийг хориод байгаа биз дээ л гэмээр байна л даа. Гэм буруутай нь тогтоогдсон, тогтоогдох хүртэл хүн болгон гэм буруугүй гэж үндсэн концепц байдаг биз дээ? Яг өнөөдөр нийгэм дээр болоод байгаа асуудал дээр нийгмийг нэлээд шуугиулж байгаад хүмүүсийг хорь хорь гэдэг ийм үйл явдлууд ч болж байна. Улс төрийн өрсөлдөгчөө намнах байдлаар нэгнийг нь хардлагаар авчирч байцааж, хорьж байгаа асуудлууд ч байна. Маш олон тохиолдлууд байгаа шүү дээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй ээ гэж заасан байгаа гэдгийг бол бас Цэцээс тухайн үед хэлсэн байна.

Тэгээд одоо энэ маргаад байгаа заалт дээр эрүүгийн хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэдэг үг дээр л авна гэж байгаа юм уу, эс үгүй бол авч болохгүй гэж байгаа юм уу тодорхой зааж өг өө гэдэг л ийм саналыг Цэцээс гаргасан, дүгнэлтийг Цэцээс гаргасан юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр 26 оны 1 сарын 1 хүртэл бид хуулиа өөрчлөхдөө яг яаж өөрчлөх юм? Авна гэх юм уу, эс үгүй бол авч болохгүй гэх юм уу? Шүүхээр гэм буруутай тогтоогдсон хойноо л хоригддог байж болохгүй юм уу? Тэрнээсээ өмнө хилийн хоригийг нь тавиад, эс үгүй бол тэр цахим гавыг нь тавиад, эс үгүй бол гэрийн хоригт нь оруулаад тэгээд олон улсад мөрдөгдөж байгаа хүний эрхийг дээдэлсэн хүний үндсэн энэ эрхийг нь хамгаалсан ийм шийдвэрүүдийг гаргаж болохгүй юм уу? Одоо тэгээд 26 оны 1 сарын 1 хүртэл Улсын Их Хурал ямар шийдвэр гаргах вэ гээд наана нь гэм зэмгүй хүмүүс бас хохирохыг үгүйсгэхгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр прокуроруудыг ч гэсэн хүнлэг байж арга хэмжээ авч болно гэдгийг авахгүй ч байж болно гэж ойлгож арай зөөлөн арга хэмжээнүүдийг авч болдоггүй юм уу гэдэг л ийм асуултыг, гуйлтыг тавих гээд байгаа юм. Тэгээд Сайнзориг гишүүнээс бид нар үүнийгээ хэрхэн яаж өөрчлөх юм бэ? Авна гэж өөрчлөх юм уу, эс үгүй бол авахгүй гэж өөрчлөх юм уу? Яг ямар бодлого явах нь зүйтэй вэ?

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Ариунзаяа гишүүний хэлж байгаа үнэн, зөв ерөөсөө л энэ хандлага руу л бид нар явж байгаа. Хүнийг ер нь зүгээр цагдан хорьж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна гэдэг бол бас тийм л юм хоцрогдчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр аль болохоор бид нар жоохон иргэнлэг буюу өөрөө эргээд энэ хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн байсан ч гэсэн тэр хүнтэй бас хүмүүнлэг, энэрэнгүй харьцах, эргээд энэ хууль тогтоомжийн дагуу эрх ашгаа бас хамгаалуулах энэ бололцоог нь бол олгох ёстой.

Тэгэхдээ хууль дээр маш тодорхой үндэслэлүүдээр цагдан хорих асуудлыг шийдсэн байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оргон зайлахыг завдсан энэ дандаа үйлдэл төгссөн үйлдлүүд байгаа. Оргон зайлахыг завдсан, эсвэл оргон зайлсан, эсвэл шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, эсвэл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа, эсвэл хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учруулах, эсвэл оргон зайлах, эсвэл хэргийн ул мөрийн эд баримтыг, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх гэмт хэрэг, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт байгаа, эсвэл урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн бол ийм л үндэслэлүүд байгаа. Ийм үндэслэлүүд бүрдээгүй байх, үүсээгүй бол хэнийг ч цагдан хорих шаардлага уг нь байхгүй. Тэгээд мэдээж энэ таслан сэргийлэх арга хэмжээний өөр бусад төрлүүд байгаа. Хилийн хориг тавих, эргээд батлан даалтад өгөх ч байдаг юм уу энэ зүйлүүдийг бид нар хэрэглэх энэ асуудал байгаа.

Тэгээд ердийн сая бас нийгэмд ч гэсэн тиймэрхүү зүйлүүд ажиглагдаж байна лээ. Аль болохоор л цагдан хорь гээд бид чинь энэ цагдан хорьж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаагаас л татгалзъя, хүний эрхийг дээрдүүлье л гэдэг бодлого байсан боловч бас ер нь зүгээр бас иргэдийг бас ойлгуулж мэдээллийг бас дутуу өгч байгаатай л холбоотой ч юм уу. Ийм сэтгэл хөдлөл дээр гарч байгаа энэ шийдвэрүүдээс бас ингэж нийгэмд нэг ийм өнгө аяс бас байгааг үгүйсгэхгүй. Энэ бас уг нь бид нарын хүсэж байгаа зам энэ биш юм байгаа юм.

Тэгэхээр дээр хэлж байгаа тэр үндэслэлүүд л бүрдээгүй бол уг нь хэнийг ч уг нь цагдан хорихгүйгээр хэрэг хянан шууд ажиллагааг илүү их бодитой хэргийн үнэнийг тогтоох энэ нөхцөл байдал руу явах ёстой. Энэ заалтын хувьд бол шүүхийн шатанд бол шүүгдэгч этгээдэд яг цагдан хорих үндэслэлүүдийг яг тодорхой заагаагүй байна. Үзэмжээрээ авч болно гэдэг ийм тодорхойгүй байдлаар зөвхөн прокурор болон хэргийн оролцогчийн саналыг үндэслэн харгалзан ингээд цагдан хорих арга хэмжээг ямар нэгэн үндэслэлгүйгээр авах нөхцөлийг бүрдүүлжээ гэдэг байдлаар л Цэц бол хандсан.

Мэдээж яллагдагчийг түрүүн цагдан хорих үндэслэлүүдийг заасантай бас энийг бол уялдуулж авч үзэж байгаа. Хэдийгээр шүүхийн шатад шилжсэн яллагдагч буюу шүүгдэгчид цагдан хориг энэ дээрх 4 үндэслэлийн дагуу л авч байгаа. Оргон зайлахыг завдсан ч юм уу, эсвэл хэргийн оролцогч шүүгч, прокурорт нөлөөлөх гэж оролдсон ч байдаг юм уу ийм үндэслэлүүдээр авч байгаа. Тэгэхээр энийгээ илүү их бас хууль зүйн бичилтийн хувьд бол ойлгомжтой нягт нямбай болгооч ээ л гэдэг энэ шаардлагыг Цэц бол тавьж байгаа л гэдэг зүйлийг энэ агуулгаараа өгсөн. Цэц бол энэ агуулгыг илүү их нарийвчлах боломжийг бас энэ

удаад өгсөн буюу бид нарт, Улсын Их Хуралд хугацаа байна. Ажлын хэсэг гаргаад холбогдох байгууллагуудыг оролцуулаад энэ асуудлыг илүү их тодруулах буюу 1 сарын 1 хүртэлх үндсэндээ бид нар чинь 2 сар гаруй ажиллачих хугацаа бол байгаад байна. Тэгээд энийг хүний эрхийг дээрдүүлэх энэ бас чиглэл рүү нь бас анхаарч хуулийг тодорхой болгох, болгоод явах нь зүйтэй л гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлттэй холбогдуулж үг хэлье. Төр улс оршиж байгаа бол заавал хамгаалах ёстой 3 эрх бол амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, өмчлөх эрх гэж Жон Лок анх удаа тунхагласан байдаг. Тэгээд энэ эрхүүд нь бол хүнтэй хамт төрдөг, хүнээс салшгүй, хэн нэгэн этгээдээс гуйдаггүй ийм эрх байдаг. Жон Локкын энэ философи болохоор манай Үндсэн хуульд бас яг тусгагдсан байгаа юм. Тэгээд төр өөрийнхөө үйл ажиллагааг нарийн журамлаж процессжуулах хэлбэрээр эрх мэдлээ хумьж хүний эрхийг хангадаг. Ингэж асуудлыг нарийн хуульчлах нь хүний эрхийн гол баталгаа болдог. Тэгээд энэ Үндсэн хуульд заасан төр иргэнийхээ өмнө хүлээсэн гол үүрэг байдаг.

Тэгээд манай Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд хүний халдашгүй, чөлөөтэй байдал, өмчийн эрхийг баталгаажуулсан ч хуулиудад нь нарийн зохицуулаагүйгээсээ болоод Үндсэн хуулийн 19.1-д заасан үүргээ төр биелүүлж чадахгүй. Энэнээс болоод хүний эрхийн зөрчлүүд үүсдэг ийм гол шалтгаанууд болж байгаа юм. Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлтэд шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг хуульд тодорхой заах, цагдан хоригдсон үндэслэлээ мэдэх болон зохисгүй удаашралгүйгээр шүүлгэх эрхээ эдлүүлэх, цагдан хоригдсон шийдвэрт гомдол гаргах болон давтамжтайгаар хянах журмыг хуульд тусгах үүргээ төр биелүүлээгүй нь Үндсэн хуулийн 19.1-ийг зөрчсөн байна гэж дүгнэсэн.

Тэгээд яг энэнтэй адилхан өмчлөх эрх дээр бас яг ийм асуудлууд үүсэж байгаа хуулийн этгээдүүдтэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх, данс хаах, үйл ажиллагааг нь зогсоохдоо энэ процессуудыг бас нарийн заагаагүйгээсээ болоод энэ хамгаалах эрхийг гүйцэтгэж чадахгүйгээсээ болоод дур зоргын шинжтэй, үзэмжийн шинжтэйгээр саяын үйл ажиллагаануудыг ингээд хийгдэж байгаа юм. Одоо бид нар том төсөл, мега төсөл хэрэгжүүлнэ, өртөг нэмэгдүүлнэ, үйлдвэр барина, жижиг дунд, аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ гээд байдаг. Тэгээд дурын байцаагч ирээд л эсвэл төрийн албан хаагч ирээд л үйл ажиллагааг нь зогсоодог. Тэгээд энэ тийм тодорхойгүй энэ орчинд ийм бололцоо боломжууд нээлттэй байна. Тэгэхээр энэ буцаад эдийн засгийн хувьд ч гэсэн асар их хохиролтой болдог. Хүний эрхийн зөрчлийн энэ асуудал нь зөвхөн энэ хууль хяналтын байгууллагын асуудал биш энэ бас улсын эдийн засаг, хөрөнгө оруулалт, иргэдийн хөдөлмөрийн харилцаатай ч гэсэн холбоотой ийм чухал асуудал байгаа.

Тэгэхээр энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авч, энэ асуудлыг илүү цогцоор нь, бүхлээр нь бас харж аливаа эрхийг хязгаарлах процессыг нарийн болгож хуульчлах зайлшгүй шаардлагатай гэж бас хэлмээр байна. Тэгээд эрх чөлөө эрхийн хамгаалалт нь ардчиллын гол тулгуур, баялаг бий болгох чухал суурь гэдгийг бас энд онцолж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл.

О.Алтангэрэл: Энэ цагдан хориотой холбоотой Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт бол их үндэстэй маш сайн гарсан шийдвэр байна гэж харж байгаа юм. Ер нь энэ цагдан хориотой холбоотой асуудал бол их эмзэг асуудал шүү дээ. Нэг хэсэг бүүр хавтгай байсан. Би энэ нөхрөөс нэг хэдэн төгрөг авах ёстой юм, хорьчихвол яг энэ яг мөнгөө өгөх гээд байна энийг нэг хорьчихмоор байна гэдэг хандлага, эсвэл хэргээ хурдан илрүүлэхийн тулд мөрдөгч аваачаад хорьчихдог тэрнийхээ дараа энэ хэргээ илрүүлнэ ээ гээд сууж байдаг. Чи мэдүүлгээ өгөх юм бол, чи тэрний талаар бичиг өгөх юм бол чамайг суллана гээд ингээд байж байдаг ийм нэг эрүүдэн шүүлтийн хэрэгсэл маягийн юм бас болчихсон байсан шүү дээ нэг хэсэг. Яагаад ийм болсон бэ гэвэл үндэслэл, журам нь тодорхойгүй байсан юм. Ямар үндэслэлээр хорих юм, ямар хугацаагаар хорих юм гэдэг юм хэтэрхий ерөнхий байснаас болж цагдан хорио, цагдан хорионы асуудал ийм хавтгай байсан.

Харин ч энэ яллагдагчийг цагдан хорьж байгаа асуудал энэ шүүхийн өмнөх шатад цагдан хоригдож байгаа асуудал манай Баттөмөрийн Энхбаяр сайд өөрөө хуульч хүний хувьд энэ эрүүгийн процессын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санаачилж 23 оны сүүлээр санаж байна ингээд батлуулаад ингээд ямар тохиолдолд цагдан хорих юм, үндэслэл нь юу байх юм гээд, тэр байтугай энэ хөнгөн гэмт хэрэгт цагдан хорихгүй зэрэг дэвшлүүд энэ үед гарсан. Одоо бид нар үргэлжлүүлээд энэ шинэчлэлийг цагдан хорио дээр хийсэн. Манай Энхбаяр сайдын хийсэн энэ шинэчлэлийг. Одоо бид нар улам гүнзгийрүүлээд шүүгдэгчийг цаашдаа цагдан хоривол үндэслэлийг нь дурддаг байх энэ нөхцөлийг бол зайлшгүй оруулах ёстой.

Тэгэхгүй бол амьдрал дээр юу болдог вэ гэхлээр зарим шүүгч нар бол хэтэрхий бүдүүлэг гэдгийг нь хүлээн зөвшөөрдөг ч гэсэн, өөрсдөө хүлээн зөвшөөрдөг ч гэсэн хэрэг явуулахгүй байна, өмгөөлөгч нь ирээгүй юү тээ хорьчихёо гээд хорьчихдог. Хурлаа хийлгэтэл чамайг хорьж байгаад хурал хийлгэнэ ээ гэдэг. Ингээд бүүр хурал хурдан хийх хэрэгсэл болгож манай гишүүдийн хэлээд байгаа энэ хүний эрхийг шууд цагдан хорих асуудлыг шийддэг. Энэ хандлага руугаа хүртэл явсан.

Ийм болохоор бид нар сая Энхбаяр гишүүний хэлж байгаа, манай Сайнзориг гишүүний хэлж байгаа эдгээр зүйлүүдийг анхаарч, Монгол Улсын Их Хуралд хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд Эрүүгийн процессын хуульд Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэрийг хүлээж авч өөрчлөлт оруулах нь зүйтэй. Энэ бол шүүгдэгчийг цагдан хорих байдал тодорхойгүй байгаагаас шалтгаалан олон сар хоригдож байгаа шүүгдэгчдийн асуудал. Энэ бол энэ шүүх шүүн тасалж байгаа процессыг хурдан явуулна гэдэг нэрийн дор олон хүний эрх зөрчигдөж байгаа асуудал. Энэ бол өөрсдийнх нь хоригдож байгаа үндэслэлийг мэдэхгүй би нэгэнт шүүх дээр оччихсон юм чинь би ингээд хоригдоод л байж байгаа гэж Монгол орны өнцөг булан бүрд аймаг болгоны Цагдан хорих төв, Улаанбаатар хотод Хорих-461 дүгээр ангид хоригдож байгаа хүмүүс, цаашдаа хоригдох хүмүүсийн асуудал учраас бид энэхүү шийдвэр.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдөр 3 Байнгын хорооны хэлэлцүүлэг бас зэрэгцэж явж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу санал хураалтыг маргааш нэгдсэн чуулган эхлэхэд өглөө 10 цагаас чуулганы хуралдааныг эхэлсний дараагаар явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд өнөөдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.28 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

